

Төлөвлөгөөг хянасан:

Хэнтий аймгийн Засаг дарга  
(албан тушаал)

Төлөвлөгөө баталсан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
(албан тушаал)



Төсвийн Ерөнхийлөн захира

Ц.Чогсомжав

(гарын үсэг)  
(огноо)

Төсвийн Шууд захирагч

Ж.Ганбаатар

(гарын үсэг)  
(огноо)

**БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь	ХШУХ-ийн үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:</b>								
<b>БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>Зорилт 1.1. "Ковид-19" болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг 92 хувьд хүргэнэ.</b>								
1	ЗДҮАХХАХТ 1.1.1. Эмнэлгийн нэг удаагийн багаж хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдлыг хангана.	-	Бэлэн байдлын хувь	70%	80%	Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахалд хэрэглэгдэх 6 оношийн бүлгийн нийт 54 нэр төрлийн эм, 16 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 5 нэр төрлийн ариутгалын бодисын нөөцөд тасалдал үүсээгүй. Нөөцийн бэлэн байдлын хангалт 83% байна.	100	100
2	ЗДҮАХХАХТ 1.1.2. Халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, тандалт сэргийлэлтийн ажлыг зохион байгуулна.	-	зорилтот бүлгийн хамрагдал 45%	зорилтот бүлгийн хамрагдал 45%	Зорилтот бүлгийн хамрагдал 53%	Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлсэн 43000 гаруй иргэнийг халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгаанд хамруулж, 28250 хүнд НЭМҮТ, ЭМЯ-аас бэлтгэн гаргасан 15 төрлийн зөвлөмж, гарын авлага хүргэсэн. "1000-уулаа МЭДЭЭЛЛЭЭ БҮҮСТЛЭЭ", "Коронавируст халдварын Омикрон хувилбараас сэргийлцгээе" аяны мэдээллийг 410 нүүр хуудас, 805 групп хуудсаар түгээж сургалт сурталчилгаанд зорилтот бүлгийн хүн амын 55.7%-ийг хамруулсан.	100	100
<b>Зорилт 1.2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.</b>								

3	ЗДҮАХХАХТ1.2.1. Тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг эрсдэлийн түвшин бүрээр нарийвчлан гаргаж, тухай бүр тодотгож ажиллана.	-	Төлөвлөгөөг тухай бүр тодотгосон байдал	-	Төлөвлөгөөг тодотгож, холбогдох эрх зүйн акт, хэм хэмжээг боловсруулж ажилласан байна.	МУЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоолын дагуу "Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх төлөвлөгөө"-г 12 бүлэг 107 арга хэмжээтэйгээр аймгийн Засаг даргаар батлуулан, 2 удаа тодотгол хийж, бүх сум, тосгон, холбогдох байгууллага, албадад хүргүүлж, өдөр бүр сумдын эрүүл мэндийн албанаас мэдээ авч нэгтгэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 87.5%-тай байна. Эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийж, улбар шар түвшингөөс магадлал бага эрсдэл буюу ногоон түвшинд шилжээд байна. I-IV	100	100
<b>Зорилт 1.3. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор гамшгийн эрсдэлийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.</b>								
4	ЗДҮАХХАХТ 1.3.1. Гамшгийн эрсдэлийн нөөц сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвийн 1.0 хувиас доошгүйг төлөвлөж зарцуулна.	-	Хуульд заасан хувь хэмжээгээр тусгаж батлуулах	247	Жилийн төсвийн 1%	2022 онд эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд 395,8 сая төгрөгийг зарцуулахаар тооцон төсөвт тусган батлуулсан. 4-р улирлын байдлаар 131.7 сая төгрөгийг зарцуулаад байна.	100	100
<b>1.4. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлнэ.</b>								
5	ЗДҮАХХАХТ1.4.1. Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлын 30 доошгүй хувийг нэмэлтээр санхүүжүүлнэ.	-	Орон нутгийн нөөц хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр тусгаж батлуулах	120	30	Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлын 30-аас доошгүй хувь буюу 240.0 сая төгрөгийг санхүүжүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 120.4 сая төгрөгийг зарцуулаад байна.	100	100
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>								
<b>Эрүүл мэндийн салбар</b>								
<b>Зорилго 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эмчлэх арга хэмжээг эрчимжүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим системийг нэвтрүүлэн чанар хүртээмжийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</b>								
<b>Зорилт 2.1.1. Нийт хүн амын 65%-ийг, зорилтот бүлгийн 70%-ийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, үзлэг, шинжилгээнд хамруулна.</b>								

6	ЗДҮАХХАХТ 2.1.1.1. Сумдад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр зохион байгуулна.	30 сая	Зорилтот бүлгийн хамрагдалтын хувь	Зорилтот бүлгийн хамрагдалт 45%	Зорилтот бүлгийн хамрагдалт 55%	Алслагдсан хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл, эмгэгүүдийг эрт илрүүлэх зорилгоор 4 бүсийн 22 сум, тосгонд НЭмнэлэг болон 3 р шатлалын эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт зорилтот бүлгийн 13800 гаруй хүнийг хамруулснаар хөхний хавдар 2, умайн хүзүүний хавдрын сэжигтэй тохиолдол 2, уушгины хавдар 2, сүрьеэгийн шинэ тохиолдол 9, артерийн даралт ихсэх өвчний шинэ тохиолдол 21, чихрийн шижингийн шинэ тохиолдол 5, ховор тохиолдлын эмгэг 1 тус тус илрүүлж хяналтад авсан. Зорилтот бүлгийн хүн амын 55%-ийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан хүрч ажилласан.	100	100
7	ЗДҮАХХАХТ 2.1.1.2. Хүн амын 70 хувийг эрдэс бодис, макро элементийн (Д, кальци) оношилгоонд хамруулж, эмчилгээний хамрагдалтыг 20-с доошгүй хувьд хүргэнэ.		Д витамин дутагдал буурсан хувь	Иргэдийн 90%-д нь витамин Д дутагдал илэрч байна	Хүн амын Д витамин дутал 10 хувиар буурна	Нэгдсэн эмнэлэг нь Д витамин тодорхойлох аппаратаар 2021 онд хангагдсан ба уг шинжилгээг өндөр өртөгт шинжилгээний тоонд оруулж ЭМД-аас 2022 оны 8 сараас эхлэн хөнгөлөлттэйгөөр авч эхэлсэн. Нэгдсэн эмнэлэг болон хувийн лабораторид 684 иргэн (Д, кальци) оношилгоонд хамрагдаж, тэдгээрийн 581 хүн буюу 85%-д нь Д витамин дутагдал илэрч эмчилгээнд хамруулсан. Мөн коронавируст халдвартай оношлогдсон 5912 иргэнийг Д-ын эмчилгээнд хамруулснаар Д-ын дутагдлыг 8.3%-иар бууруулсан.	100	90
8	ЗДҮАХХАХТ 2.1.1.3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах сургалт сурталчилгаанд зорилтот бүлгийн хүн амыг хамруулна.	-	Хамрагдалтын хувь	53%	58%	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хүн амын дунд архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, илүүдэл жин, таргалалтаас сэргийлэх, эрүүл зөв хооллолтыг дэмжих, осол гэмтлээс сэргийлэх, "Аюулгүй байр-Эрүүл байр" аян, "Архигүй амьдралыг цогцлооё", "Давсны мэдээлэл сурталчилгааны дэлхийн 7 хоног", "Эрүүл идэвхтэй амьдрал", "Илүүдэл жингүй-Эртэч Монгол", сэтгэцийн өдрийн хүрээнд "Хариад амаръя", "Оюутны эрүүл мэндийг дэмжих нь" зэрэг олон нийтийн 32 төрлийн арга хэмжээг 28 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулснаар нийт 42800 гаруй иргэд, зорилтот бүлгийн 65% хамрагдсан. 67 төрлийн мэдээ, мэдээллийг 95 цахим хуудсаар дамжуулан түгээснээр давхардсан тоогоор 32800 гаруй хандалт авсан. 11700 гаруй иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг түгээсэн. Аймгийн хэмжээнд ахуйн осол гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх ажлын хэсэг бүрдүүлэн 616 өрхөд үнэлгээ хийснээр эрсдэл өндөртэй 19 өрхийг тодорхойлж эрсдэлийг арилгах арга хэмжээг авч ажилласан.	100	100

Зорилт 2.1.2. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, орон нутгийн анхан шатны эмч, мэргэжилтний 85 хувийг сургагч багшаар бэлтгэнэ.									
9	ЗДҮАХХАХТ 2.1.2.1 УАУЭмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх /зүү, засал, дотор, мэдрэл, ахмад, яаралтай тусламж/	-	Тусламж үйлчилгээний төрлийн тоо	2 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.	2 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь хэвтэн эмчлүүлэх 51 ортой байсныг ЭМГ-ын даргын тушаалаар өдрийн эмчилгээний 6 орыг нэмж, сонгон шалгаруулалт зарлан, зүү болон засал эмчилгээний тусламж үйлчилгээг шинээр нэмэгдүүлэн ажиллаж байна. Шинээр нэмэгдсэн зүү эмчилгээнд 912 хүн, засал эмчилгээнд 1011 хүн хамрагдсан.	100	100	
10	ЗДҮАХХАХТ 2.1.2.2. Анхан шатны эмч мэргэжилтнийг уламжлалт анагаах ухааны сургагч багшаар үе шаттай бэлтгэх	-	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний хувь	-	65%	Зүүн бүсийн хэмжээнд "Уламжлалт анагаах ухааны судлал, зүү, эмчилгээний аргачлал, тохиолдолд суурилсан" сэдэвт 2 багц цагийн танхим, практик хосолсон сургагч багшийн сургалтад 21 ЭМБайгууллагын 148 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан нь анхан шатны эмч мэргэжилтний 64.8%-ийг эзэлж байна.	100	100	
Зорилт 2.1.3. Хеликобактеритай тэмцэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлж нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвслийг эрт илрүүлж, түүнээс үүссэн өвчлөлийн хүндрэлийг 15 хувиар бууруулна.									
11	ЗДҮАХХАХТ 2.1.3.1 Хеликобактерийг илрүүлэх шинжилгээний аппаратаар хангана.	15 сая	Аппаратаар хангагдсан байдал	-	2 аппарат	Нэгдсэн эмнэлэгт ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгийн хеликобактери амьсгалаар илрүүлэх аппарат олгосон.Мөн Хэрлэн сумын 1 эрүүл мэндийн байгууллагыг аппаратаар хангаснаар нийт 2 хеликобактери илрүүлэх аппарат ажиллаж байна.	100	100	
12	ЗДҮАХХАХТ 2.1.3.2 Хеликобактерийн зорилтод насны хүн амын нарийвчилсан судалгааг гарган эрсдэлийг үнэлж 30-60 насны иргэдийн 60-с доошгүй хувийг оношилгоо, шинжилгээнд хамруулна.	-	Оношилгоо, шинжилгээнд хамрагдсан хувь	400 гаруй иргэн оношилгоонд хамрагдсан	50%	Аймгийн хэмжээнд 30-60 насны хеликобактерийн эрсдэлт бүлгийн 12365 иргэн байгаагаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 6406 иргэн түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан. Эерэг гарсан 724 иргэн ЭМД-аар аймгийн Нэгдсэн эмнэлэг болон хувийн лабораторид тоолуулах шинжилгээнд хамрагдан, эмчийн хяналтад орж, эмчилгээнд хамрагдсан байна. Эрсдэлт бүлгийн хамрагдалт 51.8% байна.	100	100	
13	ЗДҮАХХАХТ 2.1.3.3 Шинжилгээнд хамрагдсан иргэдийг эмчийн хяналтад оруулж, өвчлөлийн хүндрэлийг бууруулна.	-	Эмчийн хяналтад хамрагдсан хувь	-	30%	Нэгдсэн эмнэлгийг хеликобактери илрүүлэх шинжилгээний аппаратаар хангаж, шинжилгээнд эерэг гарсан үйлчлүүлэгчдийн 28%-ийг эмчийн хяналтад авч, эмчилгээнд хамруулж байна.	90	90	
Зорилт 2.1.4. Сүрьеэ, БЗДХалдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг 90-с доошгүй хувьд хүргэнэ.									
14	ЗДҮАХХАХТ 2.1.4.1 Сүрьеэгийн эрт илрүүлгийг зохион байгуулж, эмчилгээний хамрагдалт, чанарыг сайжруулна.	10 сая	Эмчилгээний хамрагдалтын хувь	Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 85%	сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 89%	2022 онд сүрьеэгийн 102 шинэ тохиолдол бүртгэгдэж, эмчилгээний амжилт, үр дүн 92%-тай байна. Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 3034 хүнийг хамруулж 670 хүний цэрний сорьцыг цуглуулан, хавьтлын 24 хүнийг далд халдварын эмчилгээнд оруулсан. Мөн сүрьеэгийн шинэ эмнэлэгт шаардлагатай байгаа 6.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.	100	100	

15	ЗДҮАХХАХТ 2.1.4.2 БЗДХ-ын эрт илэрүүлгийг эрсдэлт бүлгийн хүн амд зохион байгуулж, хавьтал илэрүүлэлтийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Хавьтал ирүүлэлт, эмчилгээний хамрагдалтын хувь	Эмчилгээний хамрагдалт 89%, хавьтал илрүүлэлт 0.5 байна.	БЗДХ-ын эмчилгээний хамрагдалт 94%, хавьтал илрүүлэлт 0.7	Бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэгт 1157, идэвхтэй хяналтад 44, амбулаторийн үзлэгт 173 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс шинэ өвчлөл 11, хуучин 2 өвчлөл илэрсэн. Нийт 180 үйлчлүүлэгчийг эмчилгээнд хамруулсан ба эмчилгээний хамрагдалт 100%, хавьтал илрүүлэлт 0.5%-тай байна.	71	90	
<b>Зорилт 2.1.5. Гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 45-с дээш насны иргэдийн 70-с доошгүй хувийг хамруулна.</b>									
16	ЗДҮАХХАХТ 2.1.5.2 Зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илэрүүлэх үзлэгийг гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зохион байгуулж ажиллах.		45-с дээш насны иргэдийн хамрагдалтын хувь	38.9	43%	Хавдрын үзлэг шинжилгээгээг АШУУИС-ийн Монгол-Японы нэгдсэн эмнэлэг болон УХТЭ-ийн эмч нартай хамтран зохион байгуулж, зорилтот бүлгийн 14002 иргэнийг хамруулсанаас 108 тохиолдол шинээр бүртгэгдэж, эмчийн хяналтад авсан. Зорилтот бүлгийн буюу 45-с дээш насны иргэдийн 51.5 хувийг хамруулсан. Мөн хавдрын судас бөглөх эмчилгээг 5 үйлчлүүлэгчид, зүрхний титэм судсанд стент тавих эмчилгээг 1 үйлчлүүлэгчид, тархины судасны оношилгоог 8 үйлчлүүлэгчид тус тус хийсэн.	100	100	
<b>Зорилт 2.1.6. "Эрүүл ирээдүй-Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1 промилиор бууруулна.</b>									
17	ЗДҮАХХАХТ 2.1.6.1. "Эрүүл ирээдүй" арга хэмжээг зохион байгуулна.		Хамрагдалтын хувь	-	2-12 насны хүүхдүүдийн 50%-ийг арга хэмжээнд хамруулсан байна.	Аймгийн хэмжээнд 2-12 насны 18845 хүүхэд байна. Үүнээс "Эрүүл-ирээдүй" арга хэмжээний хүрээнд зохион байгуулаж буй эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтод бүлгийн 54.0%-ийг буюу 10182 хүүхдийг хамруулсан байна. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 61,4%-д нь шүдний цоорол оношлогдож байгаа ба эрүүлжүүлэх арга хэмжээг төр болон хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэгт хийж байна.	100	100	
18	ЗДҮАХХАХТ 2.1.6.2. "Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулна.		5 хүртэлх хүүхдийн эндэгдлийн түвшин	15.8 промил	14.8	Эх, хүүхдийн чиглэлээр ЭМБ-дад зөвлөмж 6 удаа, хяналт үнэлгээ 4 удаа, цахим хурал 3 удаа хийж арга зүйгээр ханган ажилласан. Жирэмсний эрт үеийн хяналт 90.1 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдэл 8 буюу 8.3 промил болж өмнөх оны мөн үеэс 3.0 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 буюу 13.5 промил болж өмнөх оны мөн үеэс 0.5 промилиор тус тус буурсан үзүүлэлттэй байна. I-IV	100	100	
<b>Зорилт 2.1.7. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 55-с доошгүй хувийг эмчилгээнд хамруулна.</b>									
19	ЗДҮАХХАХТ 2.1.7.1 "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд вирустай иргэдийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Хамрагдалтын хувь	Элэгний Д вирусийн эмчилгээний хамрагдалт 27.9%-тай.	35%	"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 11245 иргэнийг шинжилгээнд хамруулж 7670 иргэнд элэгний вирусийн халдвар оношлогдсон. Тэдгээрийн 5137 нь В болон Д вирусийн халдвартай батлагдсаныг эмчийн байнгын хяналтад авч, 1538 иргэн идэвхжил бууруулах эмчилгээнд хамрагдсан. Эмчилгээний хамрагдалт 30%-тай байна.	90	90	

Зорилт 2.1.8. "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, нийт эрчүүдийн 60-с доошгүй хувьд хүрч ажиллана.								
20	ЗДҮАХХАХТ 2.1.8.1 Эрчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт болон эрт илэрүүлэгт хамрагдах зан зүйлд сургах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	Эрчүүдийн хамрагдалтын хувь	Эрчүүдэд зориулсан тусгайлсан нөлөөллийн арга хэмжээ хангалтгүй байна.	нийт эрчүүдийн 60%-д нөлөөлнө.	Аймгийн хэмжээнд 19-65 насны 23120 эрчүүд байгаагаас эрүүл мэндийн цогц үзлэг, оношилгоонд 8092 иргэнийг, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд 17340 иргэнийг тус тус хамруулснаар зорилтот бүлгийн 45%-д хүрч ажилласан. Өссөн дүнгээр эрчүүдийн 65.1%-ийг тус арга хэмжээнд хамруулсан байна. Мөн эрсдэлт бүлгийн эрчүүдийн дунд халдварт ба халдварт бус өвчнийг илрүүлэх үзлэг, оношилгоонд 4 сумын 284 эрчүүдийг хамруулахад 12 хувьд өвчлөл илэрснийг эмчилгээнд хамруулсан.	100	100
21	ЗДҮАХХАХТ 2.1.8.2 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит "Эрчүүдийн кабинет" байгуулах	-	Кабинет байгуулсан эсэх	-	Кабинет байгуулсан байна.	Эрчүүдийн кабинет байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулан Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар Мэс засал 2 тасгийн эрхлэгч эмчийг томилон ажиллуулж, 256 эрчүүдийг үзлэгт хамруулж, зөвлөгөө өгч ажилласан.	100	100
Зорилт 2.1.9. Яаралтай тусламжийн бэлэн байдал, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.								
22	ЗДҮАХХАХТ 2.1.9.1 Яаралтай тусламжийн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн стандартын хангалтыг нэмэгдүүлэх	-	Хангалтын хувь	62%	66%	Яаралтай тусламжийн эмийн нөөцийг 49 төрөл, хувийн хамгаалах хэрэгслийг 15 нэр төрөл, ариутгалын бодисын 5 нэр төрлийн нөөцийн бүрдүүлэлт хийж, хангалт 72%-тай байна.	100	100
23	ЗДҮАХХАХТ 2.1.9.2 Яаралтай тусламжийн бэлэн байдал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	110.4	Стандартын хангалтын хувь	Стандарт үзүүлэлттэй харьцуулахад 45% хангагдсан	49%	УТХО-р яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор 2.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн дэмжих төвд 1.1 тэрбум төгрөг, нийт 3.2 тэрбум төгрөгийн багаж тоног төхөөрөмжүүдээр хангаад байна. Мөн ОНТХөрөнгө оруулалтаар Дархан, Батширээт суманд шүдний тоног төхөөрөмж 39.0 сая төгрөг, Норовлин СЭМТөвд моргийн хөргүүр 8.0, Нэгдсэн эмнэлэгт хеликобактерийн шинжилгээ, ELISA аппарат 63.4 нийт 110.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр хангалт 58.5%-тай байна.	100	100
Зорилт 2.1.10. Эрүүл мэндийн байгууллагуудын шаардлагатай барилга, автомашин, багийн эмчийг унаажуулах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.								

24	ЗДҮАХХАХТ 2.1.10.1 Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийг барилгын асуудлыг шийдвэрлэж чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	1.7 тэрбум	шинэ барилга, өргөтгөл, засвар хийгдсэн ЭМБ-ын тоо	-	2-с доошгүй ЭМБ-ийн шинэ барилга, өргөтгөл, засвар хийсэн байна.	2022 онд Баянхутаг СЭМТөвийн их засвар 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн халдвартын эмнэлгийн их засваруудыг 175.3 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн УТХОруулалтаар нийт төсөвт өртөг 4.6 тэрбум төгрөгөөр Батноров, Дадал, Галшар, Дархан, Батширээт сумын эрүүл мэндийн төвүүдийн өргөтгөлийн барилгын ажлуудыг "Си Эйч Би Жи" ХХК, "Мандалт Констракшн" ХХК, "Баян төхөмийн хурд", "Виндер Гарден" ХХК, "Төгс Буянт Өргөө" ХХКомпаниуд хийж гүйцэтгэсэн. Барилгын ажлын явц 20-70%-тай байна. Мөн энэ онд нийт 4.3 тэрбум төгрөгийн өртөгтэйгээр шинээр баригдаж эхэлсэн Өмнөдэлгэр, Биндэр, ХБУлааны тосгоны ЭМТөвүүдийн шинэ барилгын ажлын явц 70-90%-ийн гүйцэтгэлтэй байна.	100	100
25	ЗДҮАХХАХТ 2.1.10.2 Авто машин нэн шаардлагатай Эрүүл мэндийн байгууллагыг авто машинаар хангах	-	Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо	-	2-с доошгүй ЭМБ-ийг автомашинаар хангах	2022 онд УТХОруулалтаар Нэгдсэн эмнэлэгт 157.6 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон автомашин, Батноров, Дархан, Бэрх, Өлзийт, Батширээт сумын эрүүл мэндийн төвүүдэд УАЗ-220595 маркийн нийт 224.5 сая төгрөгийн түргэн тусламжийн автомашиныг олгосон. Автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэж ашиглалтад хяналт тавин ажиллаж байна. Цаашид шинэчлэх шаардлагатай ХБУлаан, Дэлгэрхаан, Биндэр, Бор-Өндөр Тахилгат, Гурванбаян эрүүл мэндийн төвийн хүсэлтийг ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.	100	100
26	ЗДҮАХХАХТ 2.1.0.3. Багийн эмчийг унаагаар хангах		Шинээр олгосон багийн эмчийн унааны тоо	7 багийн эмчийг унаагаар хангагдсан.	3 багийн эмчийг унаагаар хангах	Багийн эмчийг унаагаар хангах ажлыг сумдын Засаг дарга нарын гэрээний хавсралтад оруулан ажиллаж, Баянхутаг, Баян-Адарга сумдууд 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр багийн эмчийг унаажуулсан. Цаашид ОНӨГазарт хүсэлт хүргүүлж хуучин автомашинуудыг эрүүл мэндийн төвүүдийн багийн эмч нарт олгуулах хүсэлтийг уламжлахаар ажиллаж байна.	66.6	90
<b>Зорилт 2.1.11. Эрүүл мэндийн байгууллагад цахим үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, мэдээллийн сан үүсгэнэ.</b>								
27	ЗДҮАХХАХТ 2.1.11.1 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, мэдээллийн сан үүсгэх	-	Гүйцэтгэлийн хувь	Цахимжуулалтын ажлын гүйцэтгэл 55%	80%	ОНТХО, ОНХС-с нийт 24.4 сая төгрөгийн 14 ширхэг компьютерыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн ЭМТөвд олгосон ба цахим программ хангалт /ehealth/ ашиглалт 75%-тай явагдаж байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт киоск машиныг ашиглалтад оруулж иргэд үзлэгийн цаг авах болон лабораторийн шинжилгээг хүлээгдэлгүй авах боломж бүрдсэн. ЭМЯ болон бусад эрүүл мэндийн байгууллагуудтай 59 удаагийн цахим хурал, сургалтыг зохион байгуулж ажилласан. Сар бүр шинээр гарсан тушаал шийдвэртэй холбоотойгоор ЭМБайгууллагууд цахим хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна. H-info-бүх ЭМБ, e-health-2 НЭ, e-hospital-25 программыг анхан шат ЭМБ, health.gov.mn-ыг бүх ЭМБ өдөр бүр үйл ажиллагаандаа ашиглаж байна.	97.5	100

28	ЗДҮАХХАХТ 2.1.11.2 Алсын зайн технологи ашиглаж оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллах	-	Алсын зайн оношилгоо нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо	АНЭмнэлэгийн 1 тасаг онлайнаар оношилгоо эмчилгээ, зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаж байна.	шинээр 3 ЭМБ-д алсын зайн оношилгоо болон мобайлыг нэвтрүүлэх	3 сумын эрүүл мэндийн төв шилэн кабельд холбогдсоноор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй цахимаар холбогдон эмнэлзүйн зөвлөгөө авах боломж бүрдсэн. Алсын зайн технологийг ашиглан аймгийн 2, 3-р шатлалын эмнэлэгтэй Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг, АНЭ эх барих яаралтай тусламжийн чиглэлээр 14, мэдрэлийн тусламж үйлчилгээний чиглэлээр 7, сэхээн амьдруулах чиглэлээр 5 удаа тус тус телемедиценээр зөвлөгөө авч ажилласан.	100	100	
<b>Зорилт 2.1.12. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эмийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн зохистой хэрэглээг сурталчилж, эрүүл мэндийн байгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.</b>									
29	ЗДҮАХХАХТ 2.1.12.1 Орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлж, сургалт сурталчилгааг эрчимжүүлнэ.	-	Бодлогын хэрэгжилтийн хувь	-	Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь 85%-д хүрсэн байна.	I-IVЭмийн бодлогын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 зорилт, 25 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө батлуулан ажилласан. Уг төлөвлөгөөнд тусгагдсан 25 үйл ажиллагаанаас хэрэгжилт хангалттай 21 арга хэмжээ, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт 84%-тай байна. Мөн орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлэх, сурталчлах ажлын хүрээнд Баян-Адарга суманд 200 орчим эрдэмтэн судлаач оролцсон "Эмийн ургамлын хэрэглээ, тархалт, нөөц, ач холбогдол" сэдэвт ЭШХурал зохион байгуулж, Хэнтий аймгийн ховор ургамлын лавлах, номыг хэвлүүлсэн.	100	100	
30	ЗДҮАХХАХТ 2.1.12.2 ЭМБайгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	-	Хамруулсан эмийн байгууллагын хувь	-	нийт эмийн сангийн 65%-ийг хамруулна.	Нийт 23 ЭМТ-үүд эмийн зохистой хэрэглээ болон антибиотикийн зохистой хэрэглээ сарын аян зохиож иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг мэдээллийг олгосон. Мөн эмч нарын жор бичилтэнд хяналт тавьж арга зүйгээр ханган ажилласнаар антибиотик эмийн жор бичилт өмнөх оныхоос 10% буурсан. "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандарт 13.3, 14.3.4, 20.2.1 заалтын дагуу сумдын 10, Хэрлэн сумын 14 эмийн санд шалгалт хийж, нийт эмийн сангийн 50%-ийг хамруулсан байна.	80	90	
<b>Биеийн тамир, спортын салбар</b>									
<b>Зорилго 2.2. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл идэвхтэй амьдрах дадал олгох нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдыг дэмжинэ.</b>									
<b>Зорилт 2.2.1. "Олимп" цогцолборын орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.</b>									
31	ЗДҮАХХАХТ 2.2.1.1 "Олимп" цогцолборт их засвар хийн, орчин нөхцөлийг сайжруулна.	90 сая	Их засвар хийсэн эсэх	-	Их засвар хийсэн байна.	2022 онд 115 сая төгрөгийн засварын ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 90%-тай, 2022 ондоо багтаж дуусна.	100	100	



32	ЗДҮАХХАХТ 2.2.1.2 Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх спорт цогцолбор байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Дэмжлэг үзүүлсэн эсэх	-	Дэмжлэг үзүүлсэн байна.	Улсын төсвийн 5.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянмөнх, Дэлгэрхаан, Дадал суманд спорт цогцолбор, Биндэр, Хэрлэн суманд сургуулийн спорт заал барьж байгаагаас Дадал сумын Спорт цогцолбор ашиглалтад орж, нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1600 хүнээр нэмэгдсэн байна.	100	100
<b>Зорилт 2.2.2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт клубуудийг магадлан итгэмжлэлд оруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нөхцөлийг бүрдүүлэн спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ.</b>								
33	ЗДҮАХХАХТ 2.2.2.1 БТСГазарт бүртгэлтэй спорт клубүүдийг шат дараатайгаар магадлан итгэмжлэлд оруулна.	-	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо	-	1-ээс доошгүй клуб магадлан итгэмжлэлд орж, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдсэн байна.	2020 оны "Эрүүл мэндийн даатгалын тухай" хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 9.12 дахь заалт хүчингүй болсноор Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олох нөхцөл цуцлагдсан ч "ХАДҮН" фитнес клубыг БСШУС-ын сайд, ЭМСайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 тоот тушаалаар батлагдсан " Спортын клубыг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу нийтлэг шалгуур, үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур, сургалт - дасгалжуулалтын чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж шаардлага хангасан тул магадлан итгэмжлэлд оруулах тухай хүсэлтийн хамт ЗГТА-БТСУХороонд хүргүүлсэн ба холбогдох хэлтсээс эцсийн үнэлгээг хийх шинжээчийн багийг томилоод байна. 2022 онд аймгийн хэмжээнд 2 фитнес клуб үйл ажиллагаа явуулж байгаа ба давхардсан тоогоор 2100 хүн хамрагдаж өмнөх 2021 онтой харьцуулахад хичээллэгчдийн тоо 420-иар нэмэгдсэн байна.	70	90
<b>Зорилт 2.2.3. Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсэдийг нэмэгдүүлнэ.</b>								
34	ЗДҮАХХАХТ 2.2.3.1. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг чадваржуулах, дэмжих, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хамтран ажиллаж, биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Нэмэгдсэн иргэдийн тоо	23 холбоонд 3000 гаруй хүн хамрагдаж байна.	Биеийн тамираар хичээллэдэг иргэдийн тоо нэмэгдсэн байна.	"Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр 32 холбоо, ТББайгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд биеийн тамираар хичээллэгчдийн тоо 10100 байгаа нь 2021 оны мөн үеэс 1600-н хүнээр нэмэгдсэн байна.	100	100

35	ЗДҮАХХАХТ 2.2.3.2 Үндэсний болон спортын их наадам зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан эсэх	-	Үндэсний спортын их наадам	"Үндэсний Спортын их наадмын анхан шатны ААШТэмцээн 8 төрлөөр явагдаж 260 тамирчин оролцсон. Үндэсний Спортын VII наадмын шигшээ тэмцээнд 74 тамирчин дасгалжуулагч оролцож 1 алт, 2 мөнгө, 6 хүрэл нийт 9 медаль хүртэж улсад 8-р байр эзэлсэн. Засгийн газрын тогтоолоор хугацаанд өөрчлөлт орж 2022 онд зохион байгуулагдсан Монголын Бүх Ард Түмний спортын XV наадамд 134 тамирчин, 18 дасгалжуулагч, 23 спортын төрөлд оролцож 23 алт, 18 мөнгө, 8 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр улсад 1-р байр эзэлж Анх удаа түрүүлсэн.	100	100	
<b>Зорилт 2.2.4. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубийн системд шилжүүлнэ.</b>									
36	ЗДҮАХХАХТ 2.2.4.1 Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагаанд уялдуулан санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөнө.	130 сая	Үр дүнд суурилсан эсэх	-	Үйл ажиллагаа чанаржиж, санхүүжилтийг үр дүнд суурилсан олгодог болсон байна.	2021 оны Өсвөр үеийн шигшээ багийн тайланг зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2022 оны А/47 тоот захирамжаар шигшээ багийн үйл ажиллагааг чанартай явуулсан спортын 13 төрлөөр үргэлжлүүлэн ажиллуулж, дасгалжуулагчийн цалин 81135.0, уралдаан тэмцээн, томилолтын зардалд 15865.0, амжилт үзүүлсэн тамирчин, дасгалжуулагчдын урамшуулалд 3000.0 нийт 100 сая төгрөгийн үр дүнд суурилсан үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн, 2022 онд спортын 13 төрөлд 367 тамирчин хичээллэж, Улс, Бүсийн 18 удаагийн уралдаан, тэмцээнд оролцож, нийт Алт-65, Мөнгө-69, Хүрэл-80 медалиудыг тус тус хүртсэн. Монгол улсын рекорд амжилтыг 1 удаа /буудлага/ шинэчилж тогтоосон ба Олон улсын хэмжээний мастер 1 /буудлага/, спортын мастер 2 /хөнгөн атлетик/, спортын дэд мастер 1 /хөнгөн атлетик/ тус тус шинээр төрсөн байна.	100	100	
<b>Боловсролын салбар</b>									
<b>Зорилго 2.3. Хүн бүрийн сурах таатай орчинг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</b>									
<b>Зорилт 2.3.1. Хэрлэн сумын яслийн барилгыг 100 ороор өргөтгөж, шаардлагатай сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна.</b>									
37	ЗДҮАХХАХТ 2.3.1.1 Хэрлэн сумын яслийн барилгыг өргөтгөнө.	-		орны тоо 50	Барилгын өргөтгөлийн ажил хийгдсэн байна.	Хэрлэн сумын шинэ барилгын бэлтгэл ажлын хүрээнд 120 хүүхдийн яслийн барилгын ажлын зургийг барилгын зураг төслийн "Ди Ти Би" ХХК боловсруулж, төсвийг "Юнирүүтс" ХХК хийсэн. Гадна холбоожуулалт, дулаан, цэвэр ус хангамж, бохир ус ариутгах татуурга, цахилгаан эрчим хүчээр хангах зэрэг техникийн нөхцөлүүдийн дүгнэлт, МХГ-ын дүгнэлт гарсан.	70	50	
38	ЗДҮАХХАХТ 2.3.1.2. 4-оос доошгүй сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна.		нээсэн бүлгийн тоо	3 суманд яслийн бүлэг ажиллуулж 4 бүлэгт 77 хүүхэд суралцаж байна.	1-ээс доошгүй цэцэрлэгт яслийн бүлэг нээнэ.	Цэнхэрмандал сумын цэцэрлэгт 13, Баянмөнх сумын цэцэрлэгт 15, Баян-Овоо сумын цэцэрлэгт 5, Баянхутаг сумын цэцэрлэгт 15 нийт 4 цэцэрлэгт 1 настай 48 хүүхдийг элсүүлэн сургаж байна.	100	100	

Зорилт 2.3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гарааны үнэлгээг жил бүр шинэчлэн тогтоож сургалтын чанарыг 5,5 хувиар ахиулж үр дүнг тооцно.								
39	ЗДҮАХХАХТ 2.3.2.1. Мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг орон нутагт зохион байгуулж, мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлнэ.		Мэргэжлийн багшийн хангалтын хувь	СӨБ багшийн хангалт 95 хувь, ЕБС 96 хувьтай байна.	Мэргэжлийн боловсон хүчний хангалт 1 хувиар нэмэгдсэн байна.	2012-2022 оны хооронд мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад нийт 253 багш хамрагдлаа. Мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь өмнөх оноос 12.3 хувиар ахисан. Багш нарын ажлын байранд нь цахимаар, орон нутагт танхимаар мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг 15 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1266 багшийг хамруулсан. СӨБ-ын үндсэн багш 100 хувь буюу өмнөх оноос 1 хувиар, ЕБС-ийн багшийн хангалт 98.3 хувь буюу өмнөх оноос 0.3 хувиар ахисан байна.	100	100
40	ЗДҮАХХАХТ 2.3.2.2. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын үр дүнг гүйцэтгэлд тулгуурлан тооцно.	8.5 сая	Чанарын ахисан байдал	математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 33%, байгалийн ухааны сургалтын чанар 40.2% -тай байна	математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 34.6%, байгалийн ухааны сургалтын чанар 36.4%-д хүрсэн байна.	Багш нарын онолын мэдлэг болон цахим орчинд ажиллах чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд математик, байгалийн ухааны багш нарын сургалтыг танхим, цахимаар 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 382 багшийг хамруулсан. Мөн Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажилласнаар байгалийн ухаан 9-р анги 36.7%, 12-р анги 43.8% нийт 40.3% буюу 10.7 хувиар; математик 9-р анги 38.95%, 12-р анги 33.32% нийт 36.1% буюу 4.3 хувиар өссөн байна. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 дүгээр индексэд үнэлэгдсэн математик, байгалийн ухааны 35 багшид 35,782,628 төгрөгийн урамшуулал олгоод байна.	100	100
41	ЗДҮАХХАХТ 2.3.2.3 Аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдээс гарааны үнэлгээ тогтоож, чанарын шалгалт авна.	5 сая		ЕБС сургалтын чанар 45,6 хувьтай, СӨБ-ын сургалтын чанар 82.5 хувьтай байна.	ЕБС, СӨБ-ын сургалтын чанарыг 1.4 хувиар ахиулна.	Сургалтын чанарыг ахиулах ажлын хүрээнд ЕБС-ийн Байгалийн ухаан, Математикийн хичээлээр сургуульд суурилсан суурь түвшний үнэлгээ хийж үзэхэд 9-12-р ангийн сурагчдыг сургалтын чанар байгалийн ухаан 9-р анги 36.7%, 12-р анги 43.8% нийт 40.3% буюу 10.7 хувиар; математик 9-р анги 38.95%, 12-р анги 33.32% нийт 36.1% буюу 4.3 хувиар өссөн байна. Гүйцэтгэлд суурилсан чанарын үнэлгээг 25 сургуулийг хамруулан авахад сургалтын чанар 46,77 хувьтай шалгагдсан. Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд үзүүлсэн дүнг үзэхэд СӨБ-ийн сургалтын чанар 78,99 хувьтай байна	100	100
Зорилт 2.3.3. Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургалтын чанарын стандартыг дэлхийн жишигт нийцүүлэх зүүн бүсийн аймгуудын төв сургууль байгуулна.								
42	ЗДҮАХХАХТ 2.3.3.1 640 хүүхдийн суудалтай сургууль, 150 ортой дотуур байрны барилгыг ашиглалтад оруулна.	-		-	-	Олон улсын хөтөлбөртэй Бэрх ЕБС-ийн 640 хүүхдийн суудалтай хичээлийн барилгыг 2022 онд Улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулж 208 суралцагчтай сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 150 ортой дотуур байранд олон улсын сургуулийн 161 хүүхэд, Бэрх ЕБС-ийн 31 хүүхэд нийт 192 хүүхэд амьдарч байна.	100	100
Зорилт 2.3.4. Судалгаанд үндэслэн зарим сургуулийн хэв шинжийг өөрчилнө.								

43	ЗДҮАХХАХТ 2.3.4.1 Судалгаа, сургалтын чанар, ажлын үр дүнгийн үзүүлэлт зэргийг харгалзан шаардлагатай сургуулийн хэв шинж, бүтцийг өөрчилнө.	-	Хэв шинж өөрчилсөн сургуулийн тоо	-	Ахлах сургуулиудад хяналт шинжилгээ хийж шаардлагатай сургуулийн хэв шинжийг өөрчилнө	Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд Хэрлэн 5 дугаар сургуулийг шинээр байгуулах, Бор-Өндөр ЦС-ийг бага сургууль, Цогцолбор сургууль болгон салгах, Өлзийт ЕБС-ийг суурь боловсролын сургууль болгох, Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэгийг бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгох саналыг танилцууллаа. Үүний хүрээнд нэмэлт судалгаа хийх ажил үргэлжилж байна.	70	50	
<b>Зорилт 2.3.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Чадварлаг багш, чанартай боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>									
44	ЗДҮАХХАХТ 2.3.5.1 Чадварлаг баг чанартай боловсрол Арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	30 сая	хэрэгжилтийн хувь	-	100	Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. БШУ-ны яам, БҮТ-тэй хамтарсан "Хэнтий аймгийн суралцагчийн сурлагын хоцрогдлыг арилгах хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2 удаа 7 судлагдахууны 315 багш ЭЕШ өгөх 345 сурагчийг хамруулан сургалт зохион байгуулж Хэрлэн сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн 400 суралцагчаас ЭЕШ-ын 8 хичээлээр таблетад суурилсан шалгалтын авахад аймгийн дундаж 44.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Тус арга хэмжээний хүрээнд 3 шилдэг сургууль, 5 цэцэрлэг, 2 мэргэжлийн хөгжлийн бүлэг, 26 багшийг 10 сая төгрөгөөр, ЭЕШ амжилт гаргасан багш, суралцагчдыг 26 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан. 1-4 дүгээр түвшний 271 багшид 277.6 сая төгрөгийн урамшуулал олгоод байна.	100	100	
<b>Зорилт 2.3.6. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.</b>									
45	ЗДҮАХХАХТ 2.3.6.1 "Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлнэ.		дэмжлэг үзүүлсэн эсэх	-	Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн байна.	Бага ангийн багш-1, Малын эмч-2, цахилгааны инженер-1, их эмч-1, сувилагч-1 мэргэжлээр суралцаж байгаа нийт 6 оюутанд 23,908,352 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. Зөгийн үүр хөтөлбөрийн тавигдах шаардлагад мэргэжил нь нийцээгүй 10 оюутанд нийт 4,800,000 төгрөгийн сургалтын төлбөрт нь дэмжлэг үзүүлсэн.	100	100	
<b>Зорилт 2.3.7. Боловсролын байгууллагын удирдах албан тушаалтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулж, сургалтын үр дүнг ажлын гүйцэтгэл дээр тулгуурлан үнэлж дүгнэнэ.</b>									

46	ЗДҮАХХАХТ 2.3.7.1 Удирдах ажилтнуудын сургалтыг зохион байгуулж, үр дүнг ажлын гүйцэтгэлд тулгуурлан тооцно		үр дүн тооцсон эсэх	Жил бүр зохион байгуулдаг ч үр дүнг тооцохгүй байна.	2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	Удирдах ажилтны зөвлөгөөнийг танхимаар 2 удаа, цахимаар 1 удаа зохион байгуулж 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго зорилтоо тодорхойлж, багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйд тулгуурлан сургалтын чанарыг сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. БСШУСайдын 803-р тушаалын /СӨБ, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх журам/ дагуу сургалтын байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажлын гүйцэтгэлийн хувиар өндөр үнэлэгдсэн 3 сургууль, 5 цэцэрлэгийг 5.3 сая төгрөгөөр шагнаж урамшуулан тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж байна. Удирдлагын академитай хамтран 25 сургууль, НТБТ, ПТК, МСҮТ, СӨБ-ын удирдах албан тушаалын 62, БШУГ-ын дарга мэргэжилтнүүдийг танхимаар Улаанбаатар хотод сургалтад хамруулж мэргэжил мэдлэгийг нэмэгдүүлсэн.	100	100
<b>Зорилт 2.3.8. Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана.</b>								
47	ЗДҮАХХАХТ 2.3.8.1 Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох ажлыг шат дараатай хийж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.	71.5	нэмэгдсэн байдал	25 сургуулиас 20 нь, 34 цэцэрлэгээс 20 нь нүхэн жорлонтой байна.	1-ээс доошгүй сургууль, цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгоно	2022 онд ариун цэврийн байгууламж шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрыг БШУЯ-аас хэрэгжүүлж буй ариун цэврийн байгууламж шинэчлэх ажлын 3, 4 р ээлжийн хөрөнгө оруулалтад бүрэн хамрууллаа. Баян-адарга, Бэрх тосгоны дотуур байр, Бэрх, Хэрлэн 1-р сургууль, Дархан, Баянмөнх сумдын цэцэрлэгийн өргөтгөл шинээр баригдсанаар нийт 6 барилга орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болсон. Энэ нь суурь түвшнээс буюу нүхэн жорлонтой сургууль 4-өөр, цэцэрлэг 2-оор буурсан үзүүлэлттэй байна.	100	100
48	ЗДҮАХХАХТ 2.3.8.2 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүүхэд ердийн сургуульд сурах, хөгжих орчинг бүрдүүлнэ.	-		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчин бүрдээгүй.	Аймгийн төвийн сургуулиудад хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ангилан сурах орчинг бүрдүүлнэ	ЕБСургуулиудын ачааллыг тэнцвэржүүлэх, сургалт зохион байгуулахад шаардагдах хүний нөөц, сургалтын орчин бүрдүүлэх зорилгоор Хэрлэн сумын 1-р сургууль Сонсгол, хэл яриа, Хан Хэнтий ЦСургууль хараа болон хавсарсан хэлбэр, Тэмүүжин цогцолбор сэтгэц, дауны хам шинж, Хэрлэн 4-р сургууль хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлээр төрөлжүүлэн ажиллаж байна. Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулан 6ш таблет, дохионы хэлний 1000 үгийн карт, гарын булчин хөгжүүлэх үзүүлэн 25 ширхэг, аутизмтай хүүхдэд зориулсан цахим хэрэглэгдэхүүн 5-аар сургуулиудыг баяжуулснаас гадна Сэргээн засах үндэсний төв, дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 6 сургуулийн 20 багшийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн болон дохионы хэлний анхан шатны сургалтад хамрууллаа. Тэмүүжин ЦС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн байгууламжийг шинээр хийж гүйцэтгэлээ. Мөн Сэргээн засах үндэсний төв дохионы хэлний багш бэлтгэх сургалтад бага ангийн 1 багшийн сургалтын төлбөрийг орон нутгаас бүрэн хариуцан сургаж, амьжиргааны тэтгэмж олгож байна.	100	100

**Зорилт 2.3.10. Бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын сантай болж, цахим сургалт зохион байгуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана.**

49	ЗДҮАХХАХТ 2.3.10.1 Боловсролын салбарын цахим платформын хүрээнд ЕБС-ийн цахим хичээлийн санг нэмэгдүүлнэ.	-	нэмэгдсэн байдал	Цахим шилжилтэд 2 сургууль хамрагдаж байна.	цахим шилжилтэд хамрагдсан сургуулийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.	Цахим шилжилтийн хүрээнд СӨБ-ын хувьсах зардлын 0,4 хувь, ЕБС-ийн хувьсах зардлын 1 хувийг багш нарын ДАТА багцын хэрэглээнд зарцуулахаар төсөвт 242,778.50 төгрөг суулгасан. Сургалтын цахим платформд бүх сургууль хамрагдаж, гэрээгээ байгуулан санхүүжилтийн хуваарийн дагуу төлбөрөө төлөн үйл ажиллагаагаа эхэлсэн. 25 сургууль "Гранд ай ти", "ЕСМ", "амжилт дотком", "дигитал эдү менежмент" зэрэг компаниудтай хамтран цахим платформын хөгжүүлэлтийг хийж 145,8 сая төгрөг зарцуулсан.	100	100
50	ЗДҮАХХАХТ 2.3.10.2. Цахим хичээлийг онлайннар болон Фэйсбүүк, байгууллагын цахим хуудсаар дамжуулан явуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана.	-	Иргэдийн хувь	34%	Нийт иргэдийн 27 хувьд сургалт зохион байгуулсан.	Насан туршийн боловсролын төв нь бүх насны суралцагч иргэдэд зориулсан цахим сургалтын сандаа 350 гаруй цахим сургалтын нөөцтэй болсон бөгөөд сургалтын сэдвүүдийг албан байгууллага, аж ахуй нэгжид түгээж цахим болон онлайн захиалгат сургалтыг зохион байгуулж байна. Давхардсан тоогоор 502 сургалтад 26154 иргэн буюу нийт иргэдийн 37.3 хувийг хамруулсан байна.	100	100

**Зорилт 2.3.12. Суралцагчдын мэдээлэл технологийн чадварыг сайжруулах зорилгоор ЕБС-ийн 1 компьютерт ногдох хүүхдийн тоог бууруулж, сургуулиудын интернэт хурдыг нэмэгдүүлнэ.**

51	ЗДҮАХХАХТ 2.3.12.1. ЕБС-иудын суурин компьютерийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	-	буурсан байдал	1 компьютерт ногдох хүүхдийн тоо 18 байна.	ЕБС-ийн нэг компьютерт ногдох хүүхдийн тоо буурсан байна.	17 сургуульд 195 компьютер нэмэгдүүлэх шаардлагатай байсныг сумын Засаг дарга нарын гэрээнд тусгуулсан.2022 онд 3 сумын Засаг дарга 5 сургуульд 21 компьютер мөн нөхөн хангалтын зардлаар 158 зөврийн, суурин компьютероор нэмэгдүүлснээр нийт тоо 593 болж 1 компьютерт ногдох хүүхдийн тоо 12.7 болж буурсан. Мөн сургалтад ашиглах 293 таблетаар 27 мэдээлэл технологийн танхимыг баяжуулахаар боллоо. Цахим Хэнтий төслийн хүрээнд Хэрлэн сумын 4 сургуулийн интернэтийн хурдыг 20mb нэмэгдүүллээ. Ингэснээр тус сургуулиуд 40mb хурдаар интернэт хүлээн авч байна.	100	100
----	---	---	----------------	--	---	---	-----	-----

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар**

**Зорилго 2.4. Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.**

**2.4.1. Иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.**

52	ЗДҮАХХАХТ 2.4.1.1 Нийгмийн даатгалын багц хуулийг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	сургалтад хамрагдсан хүний тоо, шинээр даатгуулагчийн тоо	305 удаагийн сургалтад 16277 иргэд даатгуулагчийг хамруулж, сайн дурын даатгалд 4790 даатгуулагч хамрагдсан.	Сургалт сурталчилгаанд хамрагдах даатгуулагчийн тоог жилд 5 хувиар, сайн дурын даатгалд шинээр 1100-с доошгүй даатгуулагчийг хамруулна.	Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн өөрчлөлт, хэрэгжилтийн талаар иргэд даатгуулагч, ажил олгогчдод 310 удаагийн сургалт зохион байгуулж 17202 иргэд, даатгуулагчдыг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 925 даатгуулагчаар нэмэгдсэн буюу 5,6 хувиар өссөн байна. Сайн дурын даатгалд шинээр 1383 даатгуулагч хамрагдсаны 625 малчин даатгуулагч байна. Хэвлэл мэдээллийн байгууллага, цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан давхардсан тоогоор 160,000 гаруй иргэдийг мэдээллээр хангасан.	100	100	
53	ЗДҮАХХАХТ 2.4.1.2. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	ЭМД-д шинээр хамрагдсан малчдын тоо	эрүүл мэндийн даатгалд 3195 малчин хамрагдсан.	ЭМДаатгалд 200-с доошгүй даатгуулагчийг хамруулна.	Сумын Засаг дарга нарын гэрээнд эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх заалтыг тусган, удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулж ажилласнаар 2895 малчныг шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Эрүүл мэндийн даатгалд хамруулах, насны бүлгийн үзлэгийн мэдээлэл сургалт сурталчилгааг 18 төрлийн мэдээлэл бүхий материалыг 21650 иргэнд тарааж, 41100 хүний хандалт авч, 18700 хүн хуваалцсан.	100	100	
<b>2.4.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт болон байгууллага иргэдийн захиалгаар оюутнуудыг бэлтгэн төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.</b>									
54	2.4.2.1. Эрэлттэй мэргэжлээр оюутнуудыг бэлтгэн төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.	-	Ажлын байртай болсон төгсөгчдийн хувь	63%	Нийт төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.	Тухайн хичээлийн жилд / 2020-2022/ эрэлттэй ойжуулагч, аяллын хөтөч, хүнсний ногооны фермер мэргэжлүүдээр оюутнуудыг бэлтгэж төгсөгчдийн 70.0%-ийг ажлын байраар хангасан.	70	100	
<b>2.4.3. Сумдын ХАБЭА-ын зөвлөлөөр дамжуулан хяналтыг сайжруулж үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.</b>									
55	ЗДҮАХХАХТ 2.4.3.1 Сумдад ХАБЭА-ын зөвлөл, байгууллагуудад үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой болгож үйл ажиллагааг тогтмолжуулна.	-	Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой байгууллагын тоо	ХАБЭА-ын зөвлөлтэй 8 сум, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой 15 байгууллага байна.	80 байгууллагыг үйлдвэрийн ослыг судлан бүртгэх комисстой болгоно.	2022 онд 18 сум, 3 тосгонд ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, шинээр 150 байгууллага үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой болж, хөдөлмөрийн чадвар алдалт, ажлын байран дахь осол гэмтлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.	100	100	

56	ЗДҮАХХАХТ 2.4.3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогч болон ажилтнуудад зориулсан сургалт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах	2.0 сая	Зохион байгуулсан сургалтын тоо	-	2 сургалт зохион байгуулна.	2021 онд 4 удаагийн сургалтаар 401 иргэнд, 2022 онд 11 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2875 иргэнд сургалт мэдээллийг хүргэсэн. Нийт 15 удаагийн сургалтыг 3276 иргэдэд хийсэн.	100	100	
<b>Зорилт 2.4.4. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд шинэ ажлын байрыг 450-аар нэмэгдүүлнэ.</b>									
57	ЗДҮАХХАХТ 2.4.4.1. Улсын болон орон нутгийн төсвийн бүтээн байгуулалтын хүрээнд жил бүр 120-оос доошгүй шинэ ажлын байрыг нэмэгдүүлнэ.		Бүтээн байгуулалтын хүрээнд ажлын байртай болсон иргэдийн тоо	286 иргэнийг ажлын байрар хангасан	Бүтээн байгуулалтын хүрээнд 120-аас доошгүй иргэнийг ажлын байраар хангана.	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа 40 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн орон нутгийн нийт 305 иргэнийг улирлын болон түр ажлын байраар хангасан.	100	100	
<b>Зорилт 2.4.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Бизнесээ эхэл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>									
58	ЗДҮАХХАХТ 2.4.5.1. Бизнесээ эхэл арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр сургалт, нөлөөллийн ажилд 400, төсөл хөтөлбөрт 2000 иргэнийг тус тус хамруулна.	5.0 сая	Сургалтад хамрагсан иргэдийн тоо Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	284 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтанд, 361 иргэнийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулсан.	100-аас доошгүй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад, 500 иргэнийг төсөл хөтөлбөрт хамруулна.	"Бизнесээ эхэл" арга хэмжээний хүрээнд 2022 онд 1.3 тэрбум төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 1152 иргэнийг хамруулж, 212 байнгын ажлын байр, 940 түр ажлын байр бий болгосон. Мөн 2021 онд 284 иргэн, 2022 онд 330 иргэнийг нийт 614 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулсан.	100	100	
59	ЗДҮАХХАХТ 2.4.5.2. Ажил олгогч туслах малчинтай хуулийн хүрээнд гэрээ байгуулан ажиллана.		Гэрээлэн ажиллуулсан туслах малчдын хувь	93 иргэнтэй гэрээ байгуулан ажилласан	Туслах малчны судалгаанд үндэслэн нийт туслах малчдын 30-аас дээш хувийг гэрээлсэн байна.	2021 онд хийгдсэн судалгаагаар 160 малчин өрх туслах малчнаар ажиллах хүсэлт гаргасан. 2022 онд 7 сумын 131 туслах малчин өрхтэй хуулийн хүрээнд гэрээ хийсэн бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан малчин өрхийн 82% байна.	100	100	
<b>Зорилт 2.4.6. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах "Халамжаас-Хөдөлмөрт" бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>									



60	ЗДҮАХХАХТ 2.4.6.1 Халамжаас-Хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд зорилтод өрхийн 2400 иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадвар ахиулах сургалтад хамруулж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 265 өрхийн 600 иргэнийг ажлын байраар хангана.		ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	167 иргэнийг ажлын байраар хангасан	600-аас доошгүй иргэнийг сургалтад хамруулж, ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагддаг 150-аас доошгүй иргэнийг ажлын байраар хангана.	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж 2021 онд 605, 2022 онд 656, нийт 1261 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, бүлгийн сургалт, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж, 2021 онд 167, 2022 онд 279 нийт 446 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан.	100	100	
<b>Зорилт 2.4.7. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ.</b>									
61	ЗДҮАХХАХТ 2.4.7.1 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийн зөрчлийг арилгуулж хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байгууллагын тоог нэмэгдүүлнэ.	-	Хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	48 байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийж сайжруулах чиглэлээр зөвлөмж өгсөн.	20-аас доошгүй төрийн болон ААНБ-уудад үнэлгээ хийж хүртээмжийг сайжруулна.	2021 онд Хэрлэн сумын 20 байгууллага, 12 сумын сургууль цэцэрлэгт, 2022 онд 21 сум, тосгоны эрүүл мэндийн төвд, Хэрлэн сумын 7 эрүүл мэндийн төв, нийт 60 байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн хүртээмжийг сайжруулахаар ажилласан.	100	90	
<b>Зорилт 2.4.8. Ахмадын хөгжлийн төв болон ахмад настны чадамжийг дэмжиж 178 байгууллагад ахмадын сан байгуулна.</b>									
62	ЗДҮАХХАХТ 2.4.8.1. 178 байгууллагад ахмадын сан байгуулж ахмадуудад зориулсан үйл ажиллагааг тогтмолжуулна.	-	Ахмадын сантай болсон байгууллагын тоо	Ахмадын сантай 51 байгууллага байна.	70-аас доошгүй байгууллага ахмадын сантай болно.	Аймгийн ТЕЗ-ийн хүрээний 178 байгууллага ахмадын сангийн данстай байх байснаас 2022 он гарснаар аймгийн хэмжээний ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТөвийн нийт 103 төсөвт байгууллага Улсын төсвийн байгууллага болж хасагдсанаар Орон нутгийн нийт 75 байгууллагаас 70 төсөвт байгууллага ахмадын сангийн данстай болж 93 хувьтай хэрэгжиж байна.	100	100	
<b>Зорилт 2.4.9. Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй орон нутаг болно.</b>									
63	ЗДҮАХХАХТ 2.4.9.1. Хүүхдэд ээлтэй байдлын индексийг жилд нэг нэгжээр ахиулна.	10 сая	Хүүхдэд ээлтэй байдлын индекс	Хүүхдэд ээлтэй байдлын индекс 4 байна. /1-10/	Хүүхдэд ээлтэй байдлын индекс 1 нэгжээр ахисан байна.	Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилт 83.5% тай байна. Хүүхдэд ээлтэй байдлын индекс өмнөх оноос 1 %-аар ахиж, 7.3 болсон.	100	100	
<b>Зорилт 2.4.10. Жендэрийн чиглэлээр орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</b>									

64	ЗДҮАХХАХТ 2.4.10.1 Жендэрийн тэгш байдлыг хангах салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.		Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо - хамрагдалтын хувь	30 сургалт, нөлөөллийн ажилд нийт хүн амын 33 хувийг хамруулсан.	Урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа 8 удаа зохион байгуулж, нийт иргэдийн 25 хувийг сургалтад хамруулна.	Жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн аян 1, хэлэлцүүлэг 2, өдөрлөг 4, явуулын үйлчилгээ 1, нөлөөллийн 4 төрлийн 8 удаагийн үйл ажиллагаа, 2 төрлийн сургалтаар нийт 27,032 иргэн буюу нийт иргэдийн 34.1%-ийг хамруулсан.	100	100	
65	ЗДҮАХХАХТ 2.4.10.2. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх НЦҮТ-ийг стандартад нийцүүлэн 24 цагийн үйл ажиллагаатай болгож, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэнэ.	15 сая	Шийдвэрлэсэн төсөв	2 нийгмийн ажилтны цалин 15 сая төгрөгийг шийдвэрлэсэн	Шаардлагатай төсвийг шийдвэрлэнэ.	Нэг цэгийн үйлчилгээний төвийг 24 цагаар үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах хүрээнд нийгмийн ажилтан болон харуул хамгаалалтын ажилтны цалин болон эм, тариа, бусад зардалд шаардагдах 15,000,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Тус байранд 2 өрөөг нэмэгдүүлэн өргөтгөл хийж тохижуулсан. Хүний нөөцийн хувьд 2 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч, 1 халамжийн ажилтан, 1 үйлчлэгч нийт 5 ажилтантай ажиллаж байна.	100	100	
<b>Зорилт 2.4.11. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жил тутам залуучуудын оролцоог 50 хувиар, үйл ажиллагаанд хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.</b>									
66	ЗДҮАХХАХТ 2.4.11.1. Залуучуудын оролцоотой сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, сайн дурын үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцсон залуучуудыг дэмжиж урамшуулах /донорууд г.м/	20 сая	Сайн дурын ажилд бүртгүүлж, үйл ажиллагаанд оролцсон залуучуудын тоо	Сайн дурын залуучуудын бүртгэх, ажилд оролцуулах эхлэл тавигдаж байгаа бөгөөд Хэрлэн суманд 65 залуучуудыг сайн дурын ажилтнаар бүртгээд байна	Залуучуудын оролцоотой сайн дурын үйл ажиллагааг 10 хувиар нэмэгдүүлж, сайн дурын залуучуудын тоо 70 болно.	Олон нийт, иргэд, залуучуудад сайн үйлсийн үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор сайн үйлсийн аян зохион байгуулж 5 сум, 2 байгууллага, 6 ангийн 700 гаруй залуучууд нэгдэн оролцсон. Мөн аймгийн залуучуудын хөгжлийн зөвлөл сайн дурын ажилд нэгдэн "Боловсон бол гоё" уриан дор хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор Эрдэмбаян 4-р сургуульд номын булан тохижуулсан гэх мэт 13 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан нь 2021 онтой харьцуулахад 62.5 хувиар өссөн байна. Идэвх санаачилга гарган оролцсон 3 залуу, 5 ангийг алдаршуулсан. Сайн дурын ажилтнаар 2022 онд 5 хүнийг бүртгүүлж, нийт 70 залуучууд YDC.mn -д бүртгүүлээд байна.	100	100	

67	ЗДҮАХХАХТ 2.4.11.2. Хэнтий аймгийн 18 сум 3 тосгоны Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн туршлага солилцох, цаашдын үйл ажиллагааг идэвхжүүлэх чуулга уулзалтыг зохион байгуулах		Чуулга уулзалт зохион байгуулсан эсэх	Цахимаар зохион байгуулсан	Чуулга уулзалтыг 1 удаа зохион байгуулна.	Хэнтий аймгийн хэмжээнд нийт 25 залуучуудын хөгжлийн салбар зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хурал, "Залуусын оролцоо зохистой хөдөлмөр эрхлэлт" чуулганыг зохион байгуулсан. Чуулганд танхимаар 80, цахимаар 76 хүн оролцож залуучуудад тулгамдаж буй 6 дэд сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн ЗХЗ-ийн гишүүд аймгийн Засаг даргатай уулзалт зохион байгуулж хэлэлцүүлгээс гарсан саналыг уламжлан 2022-2023 онд 5 ажил дээр хамтран ажиллахаар хэлэлцсэн.	100	90
<b>Зорилт 2.4.12. Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.</b>								
68	ЗДҮАХХАХТ 2.4.12.1 ИНБ-уудын чадавжуулах сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах	30 сая	Хамтран ажилласан ТББ-ын тоо	1 сургалт зохион байгуулж, 6 ТББ-тай гэрээлэн ажилласан	4-өөс доошгүй ИНБ-тай хамтран ажиллана.	Хууль эрх зүйн хэлтэс 2, Нийгмийн бодлогын хэлтэс 1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс 1 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-д болон залуучуудын сайн дурын клуб, ИНБ-уудын төлөөллийг 2 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд хамруулсан.	100	100
69	ЗДҮАХХАХТ 2.4.12.2. Улаан загалмайн байгууллагатай хамтран ажиллана.	30 сая	Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	Төр улаан загалмайн хамтын ажиллагааны зөвлөлийн төлөвлөгөөний дагуу хамтран ажилласан. Улаан загалмайн хороонд 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	Сургалт зохион байгуулж, хамтран ажилласан байна.	Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, аймгийн улаан загалмайн байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж, Төр-Улаанзагалмайн хамтын ажиллагаа, Хүндэт донор алдаршуулах, Гамшгийн менежмент, Хүүхэд залуучуудын хөтөлбөр гэсэн 4 чиглэлийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлсэн.	100	100
<b>Соёл, урлагийн салбар</b>								
<b>Зорилго 2.5. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай соёлын бүтээлийг дэмжин соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадвар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</b>								
<b>Зорилт 2.5.1. Аймгийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэж, Сэцэн ханы ордон музейг хуучны загварт оруулж, сэргээн засварлана.</b>								

70	ЗДҮАХХАХТ 2.5.1.1. Аймгийн музейг ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэнэ.	3 тэр бум	Шинээр дэглэсэн үзмэрийн тоо	-	Үзмэрийг шинээр дэглэсэн байна.	Аймгийн шинэ музейн барилга 100% баригдаж, ашиглалтад орсон. Үзмэр дэглэлтийг хийхээр улсын төсвийн хөрөнгөөр 4 багц тендер зарлагдсанаар холбогдох 3 компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Үзмэрийн шилэн хоргыг хийхээр шалгарсан "Синема оф саунд" ХХК-с BL-1 загварын 5 ширхэг шилэн хорго, тендерийн 2 болон 3 дугаар багцад шалгарсан "Голден Хоул" ХХК-аас холбогдох тавилга эд хогшил тоног төхөөрөмжийг нийлүүлэн үзүүлэг дэглэлтийн ажил 80%-тай хийгдэж байна.	100	100
<b>Зорилт 2.5.2. Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.</b>								
71	ЗДҮАХХАХТ 2.5.2.1. Монгол үндэсний уламжлалт морь, бөх, сур, шагайн спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулж, хэвшинэ.	50сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлсэн байна.	Нийт 13 суманд Монгол үндэсний уламжлалт соёл спортын 42 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 13797 иргэд, хүүхэд, залуучууд хамрагдсан. Орон нутагт үндэсний сур, шагайн харвааны сургалт 8 удаа, үндэсний бөх, сур харваа, ширээний шагай, шагайн харваа зэрэг төрлүүдээр тэмцээн уралдаан 54 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 2900 гаруй иргэд хамрагдсан ба 18 сум, 3 тосгонд 1012 иргэн үндэсний спортын төрлөөр тогтмол хичээллэж байна. Их хурд-9 хурдан морины уралдаан, Аймгийн аварга шалгаруулах шагайн харваа, Үндэсний спортын 7-р наадмын сорилго сурын харваа, "Монгол бахархлын өдөр"-т зориулсан үндэсний бөхийн барилдаан зэрэг 4 арга хэмжээнд нийт 18,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100	100
<b>Зорилт 2.5.3. Хэнтий аймгийн онцлог, соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлагийн бүтээлийг дэмжин хөгжүүлнэ.</b>								
72	ЗДҮАХХАХТ 2.5.3.1. Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд "Чингис хаан дуулалт жүжиг" бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлж, олны хүртээл болгоно.	150 сая	"Чингис хаан дуулалт жүжиг" туурвисан эсэх	-	"Чингис хаан дуулалт жүжиг" бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлсэн байна.	Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд УГЗ, Төрийн шагналт, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, МУ-ын Төрийн дээд Чингис хаан одонт Б.Шаравын "Чингис хаан дуулалт жүжиг"-ийн зохиолыг 21 сая төгрөгөөр худалдан авч бүтээлийн судалгааны ажил хийгдэж байна.	90	90
73	ЗДҮАХХАХТ 2.5.3.2. Баян-Адарга суманд "Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв" байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	500 сая	Мэдээллийн төв баригдсан эсэх	-	Мэдээллийн төв баригдсан байна.	ШУА-ийн Археологийн хүрээлэн болон музейн албан хаагчдын бүрэлдэхүүн Баян-Адарга суманд ажиллаж "Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв"-ийг байгуулах 2 га газрын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, гэрчилгээ аван зургийн даалгаврыг аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлж байна.	100	50
<b>Зорилт 2.5.5. Хан Хэнтий нутгийн түүх, соёлын биет болон биет бус өвийг хадгалж, хамгаалах, өвлүүлэх цахим мэдээллийн сан бүрдүүлнэ.</b>								

74	ЗДҮАХХАХТ 2.5.5.1 Сумдын соёлын төвийг орчин үеийн зургийн аппаратаар хангаж, цахим сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	15 сая	Аппаратаар хангагдсан соёлын төвүүдийн тоо	-	6-аас дээш соёлын төвийг зургийн аппаратаар хангасан байна.	4 сумын соёлын төв орчин үеийн зургийн аппаратаар хангагдаж, соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах цахим сан бүрдүүлэх ажил амжилттай явагдаж байна.	90	90	
75	ЗДҮАХХАХТ 2.5.5.2. Биет бус өвийг хадгалж, хамгаалах цахим мэдээллийн сан бүрдүүлнэ.	-	Биет бус өвийн цахимжуулсан хувь	-	Биет бус өвийн 40 хувийг цахимжуулсан байна.	Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, өвлүүлэн үлдээх цахим мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор СББӨ-ийн улсын бүртгэл мэдээллийн сан бүртгэлтэй 763 өвлөн уламжлагчаас 320 өвлөн уламжлагчийн фото болон видео мэдээллийг цуглуулан цахим мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаа. Цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажил 41.9%-ийн гүйцэтгэлтэй байна.	100	100	
<b>Зорилт 2.5.6. Иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог хангаж “Хэнтийн түүх-бидэнд чухал” арга хэмжээг жил бүр зохион байгуулна.</b>									
76	ЗДҮАХХАХТ 2.5.6.1 Угийн бичгийн хөтлөлтийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргын сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд жил бүр тусган хэрэгжилтийг тооцон ажиллана.	-	Угийн бичгийн хамрагдалтын хувь	40%	Угийн бичгийн хөтлөлтийг 45 хувьд хүргэнэ.	Угийн бичгийн зөвлөмж, сургалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээг 127 удаа зохион байгуулж 3259 хүн хамруулсан. Аймгийн хэмжээнд 24215 өрх байгаагаас 10917 өрх угийн бичиг хөтөлж, аймгийн хэмжээнд хэрэгжилт 45.8%-тай байна.	100	100	
77	ЗДҮАХХАХТ 2.5.6.2 Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, эх хэл, англи хэл, боловсрол, соёл, урлагийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.		Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн	Хөтөлбөрүүд 90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байна	Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөрийн хүрээнд ахлах ангийн суралцагчдын дунд олимпиад, хэлэлцүүлэг зохион байгуулж 251 хүүхдийг хамруулсан. Ахлах сургуулиудын дунд Дөл тэмцээнийг зохион байгуулж шалгарсан баг улсын уралдаанд амжилттай оролцсон. БЭЛГЭГҮЙ ҮГ ХЭЛЭЛЦДЭГГҮЙ БИЛГҮҮН МОНГОЛ УХААНААС СУРАЛЦЪЯ аныг санаачлан өрнүүлж цахим орчинд 21413 хүний хандалт аваад байна. Бичиг үсгийн баярыг Баян-Овоо суманд зохион байгуулж 6 үйл ажиллагааны хүрээнд 1950 хүнийг хамруулан шилдэг оролцогчдыг 8.8 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Мөн “монгол бичиг –III” хөтөлбөрийн хүрээнд монгол бичгийн сургалтыг 20 байгууллагын 482 төрийн албан хаагчдад танхимаар 74 төрийн албан хаагчдад онлайн хэлбэрээр зохион байгуулсан.	100	100	

78	ЗДҮАХХАХТ 2.5.6.3 Уламжлал болгон зохион байгуулдаг Санжаасүрэн, Шарав, Гомбо, Дашням, Шархүүхэн багшийн нэрэмжит улсын уралдаануудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, шинээр Р.Чойномын нэрэмжит "Оюухай" яруу найргийн наадмыг 3 жил тутамд зохион байгуулна.	10 сая	Уралдаан зохион байгуулагдсан эсэх	-	Дашнямын нэрэмжит дууны улсын уралдаан зохион байгуулагдсан байна.	Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит "СЭРСЭН ТАЛ-2022" дуу хөгжмийн наадам, Орчин үеийн дуу дуулаачдын улсын 2-р уралдаанд 70 уран бүтээлч оролцсон. МУУГЗ Л.Дашнямын нэрэмжит дууны уралдааныг цахимаар зохион байгуулж, "Анир" студийн продюсер, хөгжмийн зохиолч, хөгжмийн найруулагч Бэгзсүрэнгийн Алтанхуягийн бүтээл шалгарч 5 сая төгрөгөөр шагнагдсан. Хэнтий аймгийн Р.Чойномын нэрэмжит нийтийн номын сан, Р.Чойномын -Өд сан, Хэрлэн тооно утга зохиолын нэгдэл, Дархан сумын ЗДТГ хамтран "Оюухай" яруу найргийн наадмыг амжилттай зохион байгуулж өгүүллэг уран уншлага шүлэг яруу найргийн төрлөөр 40-өөд яруу найрагчид хамрагдлаа.	100	100
79	ЗДҮАХХАХТ 2.5.6.4. Олон улсын чанартай Алтаргана, Чингис фестивал буюу ардын урлагийн наадмыг тогтмол зохион байгуулна.	20 сая,10 сая	Наадам зохион байгуулагдсан эсэх	-	Чингис фестивал ардын урлагийн наадмыг зохион байгуулна.	Алтаргана бага наадмыг аймгийн хэмжээнд удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулж 8 сумын 100 гаруй ардын авьяастнууд, спортын тамирчид хамрагдсан. Энэхүү уралдаанаас шалгарсан 61 авьяастан спортын тамирчдыг бэлтгэл хангуулан ОХУ-ын Агын тойрог болсон "Их Алтаргана - 2022" наадамд амжилттай оролцож 2 тэргүүн байр, 1 тусгай байрын шагнал хүртсэн. Чингис фестивалийг 7 сард зохион байгуулж, 66 уран бүтээлч оролцсон.	100	100
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ</b>								
<b>Санхүү, төсвийн хариуцлага</b>								
<b>Зорилго 3.1. Татварын суурийг нэмэгдүүлэн, төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлэн ил тод байдлыг хангаж, эх оронч худалдан авалтыг дэмжин, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санг шинэчлэнэ.</b>								
<b>Зорилт 3.1.1 . Татварын тайлагналт, хураалт, бүртгэлийг цахим тайлангийн системд 100 хувь хамруулан, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.</b>								
80	ЗДҮАХХАХТ 3.1.1.1 Иргэдэд үзүүлэх бүх төрлийн татварын үйлчилгээ цахимжсан байна.	-	Цахимд шилжсэн үйлчилгээний тоо	80%	90%	"Цахим татварын алба" болох зорилтын хүрээнд 2022 онд 13 төрлийн татварын тайланг 16240 ААН, иргэнээс 98.0 хувиар цахимаар ирүүлсэнийг шалгаж хүлээн авч баталгаажуулсан. Татвар төлөгчдийн татвар төлөх үйл ажиллагааг хялбарчилах, цахимжуулах зорилгоор Гэрэгэ системс ХХК, бүх сумдын ЗДТГ-тай хамтран сумдын байцаагчдыг 100 хувь пос машинаар хангаж 85869 гүйлгээгээр 624.0 сая төгрөгийн татварыг хураан авч улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн 26 татвар төлөгч, бизнес эрхлэгчээр 2807 иргэнийг нийт 2833 татвар төлөгчийг татвар төлөгчийн бүртгэлд цахимаар бүртгэн авсан. 2022 оныг "Цахим татварын алба" болох зорилтын хүрээнд програм хангамжийг бүрэн шинэчилсэнээр татварын албаны зүгээс иргэдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээ 100 хувь цахимжсан байна.	100	100

Зорилт 3.1.2. Татварын орлогын төлөвлөлтийг сайжруулж, бодитой болгох. /85%/								
81	ЗДҮАХХАХТ 3.1.2.1. Төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулна.	-	Орлогын өсөлтийн хувь	70%	Татварын орлогын гүйцэтгэл 76%	Татварын орлогын төлөвлөлтийн түвшин жилийн эцсийн байдлаар 95 хувьтай. Төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувьд 2022 онд улсын төвлөрсөн төсөвт 2620,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2734,5 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 104 хувиар, орон нутгийн төсөвт 24938,8 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 24525.5 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 98.3 хувиар тус тус биелүүлсэн	100	100
Зорилт 3.1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилтийн цахим системийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагад нэвтрүүлнэ.								
82	ЗДҮАХХАХТ 3.1.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээг цахим системд тухай бүр оруулан ажиллана.	-	Цахим системд оруулсан хувь	100%	Төсөл арга хэмжээг цахим системд бүрэн оруулсан байна. 100%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь 2022 оны 5 дугаар сарын 01-ны өдрөөс цахим системд бүрэн шилжижсэн тул мэдээллийг оруулж санхүүжилтийг олгон ажиллаж байна. 2022 оны 4-р улиралын байдлаар 30 төсөл арга хэмжээний 58 удаагийн санхүүжилтээр 25,302.3 сая төгрөгийн мэдээллийг цахим системд 100 хувь бүрэн оруулаад байна. Мөн 2022 оны 10-р сарын 11-нээс эхлэн санхүүжилтийн гүйлгээг цахимаар баталгаажуулан ААН байгууллагуу шилжүүлж байна.	100	100
Зорилт 3.1.4. Санхүүгийн хяналт шалгалтыг чанаржуулан Төрийн аудитаар илэрдэг зөрчлийг бууруулна.								
83	ЗДҮАХХАХТ 3.1.4.1 Эрсдэлд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг тогтмолжуулж мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгч, эрсдэлийг бууруулж ажиллана.	-	Эрсдэлийг бууруулсан хувь	Эрсдэл 17%	Эрсдэлийг 15%-д хүргэж бууруулах	2021 онд Төрийн аудитаар 28 байгууллага хязгаарлалттай дүгнэлт гарсан. Дээрх 28 байгууллагын 16 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 12 байгууллагад нь зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан. Үүний дүнд 28 байгууллагаас 25 байгууллага "Бага", 3 байгууллага "Дунд" эрсдэлтэй гарч эрсдэлийн түвшин 10.8%-д хүрч буурсан байна.	100	100
84	ЗДҮАХХАХТ 3.1.5. Шилэн дансны дотоод хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, төсөвт байгууллагуудын санхүүгийн ил тод байдал хангагдана.	-	Шилэн дансанд мэдээлэгдсэн хувь	87.9	95	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны "админ"-д улирлын тайлан илгээлт хянагддаг байдал 172 байгууллага байснаас 2 дугаар улирлаас хойш бүх шатны боловсролын байгууллага хасагдаж 117 байгууллага болсон. 2022 оны 4-р улирлын байдлаар нийт 16249 талбар мэдээлэл мэдээлэхээс 15469 талбар мэдээллийг хугацаандаа мэдээлж мэдээллийн иж бүрэн байдал 95.2%-тай хэрэгжиж байна.	100	100
Зорилт 3.1.5. Орон нутгийн төсөвт бүх байгууллагууд дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан тохирлын баталгаатай барааны жагсаалтад заасан барааг худалдан авах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж хэрэгжүүлэн ажиллана.								
85	ЗДҮАХХАХТ 3.1.5.2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч сумдын төсвийн ерөнхийлөн захирагчийн хамтран ажиллах гэрээнд жил бүр худалдан авах дотоодод үйлдвэрлэсэн барааны нэр төрөл үнийн дүнг тусгаж биелэлтийг дүгнэж ажиллана.	-	Хамтран ажиллах гэрээнд тусгаж хэрэгжүүлсэн байна.	625.1	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусган ажилласанба 2022 онд 2981351,7 мянган төгрөгийн дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авсан.	100	100

Зорилт 3.1.6. Худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж аймгийн хэмжээнд цахим худалдан авах ажиллагааг 100 хувьд хүргэнэ.								
86	ЗДҮАХХАХТ 3.1.6.1. Худалдан авах ажиллагааны сургалтыг зохион байгуулж анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлнэ	-	Сургалтанд хамрагдаж шинээр А-3 гэрчилгээ авсан хүний тоо	237	Анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлнэ. 320	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад 60 төрийн албан хаагч, төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл хамрагдсанаас 41 нь буюу 80% нь тэнцсэн. Хэнтий аймагт А3 гэрчилгээтэй 330 албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл байна.	100	100
87	ЗДҮАХХАХТ 3.1.6.2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч сумдын төсвийн ерөнхийлөн захирагчийн хамтран ажиллах гэрээнд цахим худалдан авалтын хүрэх түвшинг жил бүр тусгаж биелэлтийг дүгнэж ажиллана.	-	Цахим худалдан авалт 100% хэрэгжсэн байна.	51%	85%	427 төсөл арга хэмжээний урилга, үр дүн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад нийтлэгдэж Хэнтий аймгийн хэмжээнд төсөл арга хэмжээг 100% цахимаар зарлаж, үр дүнг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.	100	100
Зорилт 3.1.7. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой нийт байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, хяналт шалгалт зохион байгуулах.								
88	ЗДҮАХХАХТ 3.1.7.1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын гэрээг жил бүр бүрэн дүгнэж, эд хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтын байдлын талаарх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.	-	Гэрээ дүгнэсэн, хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	-	Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, дараа оны гэрээг байгуулсан байна. /100%/	2021 онд аймгийн хэмжээнд 184 орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээ байгуулан биелэлтийг дүгнэн, дараа оны гэрээг байгуулан ажилласан. Гэрээг хангалтгүй ажилласан байгууллагуудад арга зүйг зөвлөгөө өгсөн. 2022 онд Эд хөрөнгийн улсын үзлэг тооллоготой холбогдуулан 5 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд Баянмөнх, Дэлгэрхаан, Жаргалтхаан, 6 дугаар сарын 23, 34-ны өдрүүдэд Өмнөдэлгэр, Гурванбаян, Батширээт, Биндэр, Баян-Адарга зэрэг сумдаар эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, байгууллагын хөрөнгийн тооллогыг хэрхэн үр дүнтэй, чанартай, зохион байгуулж байгаа талаар ажлын хэсэг удирдамж гарган хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.	100	100
Зорилт 3.1.8. Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийн эзэмшигч байгууллагыг тодруулан тухайн байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулах.								



89	ЗДҮАХХАХТ 3.1.8.1 Эд хөрөнгийн ашиглагч байгууллагыг тогтоон данс бүртгэлд тусгах ажлыг тухай бүр зохион байгуулна.	-	Эд хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байдал	95	Төсөл арга хэмжээний хүрээнд шинээр бий болсон эд хөрөнгүүдийг эзэмшигч байгууллагын дансанд бүртгүүлсэн байна. /100%/	Энэ онд сумдын болон аймгийн төвийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 9 байгууллагын 5,452.6 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх, 59 байгууллагын 1,386.7 сая төгрөгийн эд хөрөнгийг актлах, 3 байгууллагын 30.2 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг балансаас баланс хооронд шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж холбогдох шийдвэрийг гаргаж тухайн байгууллагуудад хүргүүлж данс бүртгэлд тусгах ажилд хяналт тавин ажилласан. 2021 онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга, засвар, тоног төхөөрөмжийн ажлаас: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 22 ажлаас 13 байгууллага данс бүртгэлд тусгаж, 4 байгууллага гүйцэтгэлээс шалтгаалан хүлээгдэж, 5 байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 28 ажлаас 24 байгууллага данс бүртгэлд тусгаж, 4 байгууллага гүйцэтгэлээс шалтгаалан хүлээгдэж байна. Энэ оны хагас жилээс эхлэн барилга байгууламж хүлээж авах комисст орж ажиллан эд хөрөнгийн эзэмшигч байгууллагын дансанд бүртгэх ажилд арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.	100	100	
<b>Зорилт 3.1.9. Сум хөгжүүлэх болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангуудыг нэгтгэн, сангуудын эргэн төлөлтийг сайжруулж, авлагын 60 хувийг барагдуулан “Бусдад боломж олгох” арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>									
90	ЗДҮАХХАХТ 3.1.9.1 Сангуудын зээлийн эргэн төлөлтийг сайжруулж, 6.9 тэрбум төгрөгийн авлагын 60% буюу 4.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, зээл авах хүсэлтэй хувиараа бизнес эрхлэгч болон ААНэгжүүдэд олгоно.	-	Зээлийн эргэн төлөлт сайжирсан байх	40%	50%	СХСангийн эргэн төлөлт 2673.8 сая, ЖДБДСангийн эргэн төлөлт 805.8 сая төгрөгийн зээл төлөгдөж нийт 3479.6 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээд байна. Авлагыг 50.1 хувиар барагдуулсан. Энэ онд Хоршоо ХСангаас 2 сум 211.5 сая төгрөгийн зээл олгосон байна.	100	100	
<b>Хариуцлагатай уул уурхай</b>									
<b>Зорилго 3.2. Уул уурхайн үйл ажиллагаа, хяналтыг олон нийтэд ил болгож, хариуцлагатай уул уурхайг бий болгоно.</b>									
<b>3.2.1. Аймгийн нутаг дэвсгэрт шинээр уул уурхайн лиценз нэмж олголтгүй, хяналт мэдээллийг олон нийтэд ил тод болгож, хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна.</b>									
91	ЗДҮАХХАХТ 3.2.1.1 Уул уурхайн хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна.	-	тоогоор	ашиглалтын 127, хайгуулын 86, нийт 213 тусгай зөвшөөрөл байна.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл буурсан байна	Ашигт малтмалын хүчин төгөлдөр бүхий нийт тусгай зөвшөөрлийн тоо 210 байгаа нь 2021 оны 4-р улирлаас 3 тусгай зөвшөөрлөөр буурсан үзүүлэлттэй байна.	100	100	

92	ЗДҮАХХАХТ 3.2.1.2. Бичил уурхайн үйл ажиллагааг хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн ил тод, нээлттэй зохион байгуулж, "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журмын хэрэгжилтийг 80-аас дээш хувьд хүргэнэ.	-	хувиар	Журмын хэрэгжилт 52.9%тай байна.	Журмын хэрэгжилтийг 60 хувьд хүргэсэн байна.	Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам" нь Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолоор түр хязгаарлагдсан ба түүний хүрээнд хяналт тавьж хууль тогтоомжийн шаардлага хангахгүй 20 орчим нөхөрлөлүүдийн гэрээг цуцлах саналыг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 296 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан журмын танилцуулга сургалтыг Сумдын Засаг дарга, БОХУБайцаагч нарт зохион байгуулсан ба шинэ журмын дагуу гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл байхгүй байна.	100	100
Зорилт 3.2.2. Уул уурхайн компаниудын /"Нийгмийн хариуцлага"-ын хүрээнд/ нийт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний худалдан авалтын 30-аас доошгүй хувийг орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс авах ажлын зохион байгуулалтыг хийж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.								
93	ЗДҮАХХАХТ 3.2.2.1 "Нийгмийн хариуцлага"-ын гэрээг хийж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж хэвшүүлнэ.	-	хувиар	гэрээ дүгнээгүй байна.	гэрээний хэрэгжилт 100 хувь	Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах 3 талт гэрээг 165 аж ахуйн нэгжид хүргүүлсэн. 2022 оны 3 дугаар сард тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тайлант уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, 2021 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэж хэлэлцүүлээ. Гэрээний хэрэгжилт 78.3 хувьтай дүгнэгдсэн. 2022 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх хугацаа болоогүй.	78	90
94	ЗДҮАХХАХТ 3.2.2.2. Уул уурхайн компаниудад бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх боломжтой жижиг дунд үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалт, үйл ажиллагааг дэмжих замаар орон нутагт оруулах эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	-	хувиар	дотоодын худалдан авалтыг 6%-д хүргэсэн.	Уул уурхайн компаниудын нийт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дотоодын худалдан авалтыг 10 хувьд хүргэсэн байна.	8 суманд үйл ажиллагаа явуулж буй 14 аж ахуйн нэгж, уурхай дотоодын үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс 190 гаруй сая төгрөгийн худалдан авалт хийж орон нутгийн иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан нь тухайн аж ахуйн нэгжүүдийн 14 хувийг эзэлж байна.	100	100
Зорилт 3.2.3. Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ.								

95	ЗДҮАХХАХТ 3.2.3.1. Мэргэжлийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран төсөл хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	-	төсөл хэрэгжсэн эсэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2 төсөл хэрэгжсэн.	Төсөв, хөрөнгө шийдвэрлэгдсэн байна.	Бор-өндөр, Дархан сумдад хайлуур жонш баяжуулах, олборлох үйлдвэр, Бор-Өндөр суманд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн төслүүдийн хэргжилттэй танилцаж, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшил хамтран ажиллах талаар хэлэлцлээ. Мөн "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсаны дагуу аж үйлдвэрийг хөгжүүлэх, төв суурын газрын төвлөрлийг сааруулах хүрээнд "Аж үйлдвэрийн нэгдсэн парк бүхий шинэ Бор-Өндөр хот байгуулах" төслийг Засгийн газрын түвшинд хэлэлцүүлж, холбогдох хууль эрхзүйн зохицуулалтыг бий болгох, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх санал хүсэлтийг хүргүүлээд байна.	50	50
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр салбар</b>								
<b>Зорилго 3.3. "Атрын IV" аяныг хэрэгжүүлэн улаан буудайн ургац хураалтын хэмжээг 30 мянган тонн-д хүргэж, эрчимжсэн мал болон зоорийн аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнс, төмс, хүнсний ногооны хангамж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.</b>								
<b>3.3.1. Тариалангийн талбайн ашиглалтыг сайжуулан эргэлтэд оруулж, хөрсний үржил шимийг хамгаалах, хашаажуулах, сэлгээнд үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх замаар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана.</b>								
96	ЗДҮАХХАХТ 3.3.1.1 Атрын 4 дахь аян, тариалангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	гүйцэтгэлийн хувиар	Атрын 3 дахь аян хэрэгжиж дууссан.	Хэрэгжилтийг ханган ажиллана.	2022 оны тариалалтад 18 сум 5 тосгоны 40 гаруй аж ахуйн нэгж, 700 гаруй иргэн үр тариа, төмс, хүнсний ногоо, тосны ургамал, ногоон тэжээл, эмийн ургамал зэрэг таримлуудыг нийт 32.1 мянган га-д тариалсан. Үр тариа шууд хураасан 11849 га, Ангилаан хадсан 3790 га, Цайруулсан 3940 га нийт 17283 тн буюу нэгжээс 11 цн, үүнээс улаан буудай 14342 га-с 15793 тн, төмс 285 га-аас 2536 тн, хүнсний ногоо 271.5 га-аас 3231 тн, ногоон тэжээл 2845 га-аас 4269.5 тн, тосны ургамал 5858 га-аас 2153 тн, хунчир 80 га-аас 50 тн тус тус байгаагаас үр тариа 92 хувь, төмс 96.3 хувь, хүнсний ногоо 78.9 хувь, ногоон тэжээл 86 хувь, тосны ургамал 57.5 хувьтай тус тус хураан аваад байна. Атрын 4 дахь аян, тариалангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг газар тариаланчид болон холбогдох иргэдээр хэлэлцүүлсэн баталсан.	100	90
97	ЗДҮАХХАХТ 3.3.1.2 Тариалалт хийхгүй байгаа эзэмшлийн газар болон атаршсан 20.0 мянган га тариалангийн талбайг 100 хувь эргэлтэд оруулна.	-	гүйцэтгэлийн хувиар	2021 онд 5035 га газар эргэлтэд оруулсан.	жилд 5000 га-аас багагүй газрыг эргэлтэд оруулна.	5 сумын нийт 2638.3га атаршсан талбайг шинээр эргэлтэд оруулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган эзэмшүүлээд байна.	100	50

98	ЗДҮАХХАХТ 3.3.1.3. Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг эрчимжүүлнэ.	-	тоогоор	2021 онд Өлзийт, Гурванбаян тосгонд 76 км хашаажуулалт хийсэн.	Хашаажуулсан талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.	Баян-Адарга сумын "Идэр-Онон" ХХК 139га, "Мөнхийн дуурлиг" ХХК 126га нийт 265га тариалангийн талбайг "Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төслийн 152.0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулсан. Мөн Хэрлэн сумын Өлзийт тосгоны "М-АГРО" ХХК 8255га тариалангийн талбайг өөрийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр, иргэн А.Лувсандавга 450га тариалангийн талбайг өөрийн 258.1 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хашаажуулсан.	100	100	
<b>Зорилт 3.3.2. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэн, хүлэмж, зоорийн аж ахуйн хангамжийг сайжруулна.</b>									
99	ЗДҮАХХАХТ 3.3.2.1 Төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.	-	тоогоор	-	Шаардлагатай сум, тосгонд дэмжлэг үзүүлнэ.	Энэ онд Хэрлэн, Мөрөн сумдад Монгол улсын Засгийн газрын хөнгөлөлттэй нөхцөлөөр 50 морины хүчин чадалтай трактор 2ш, 80 морины хүчин чадалтай трактор 1ш, хор цацагч 2ш, сийрүүлэгч, манагч кон 1.4А 1ш, нарийн ногооны үрлэгч 1ш, чиргүүл 1ш, 3 корпустай плуг 1ш тус тус олгосон. Мөн ОНТөсвийн 85.0 сая төгрөгийн хөрөнгөөр Цэнхэрмандал суманд 120 морины хүчин чадалтай 1 трактор тус тус шийдвэрлэсэн.	100	100	
100	ЗДҮАХХАХТ 3.3.2.2 Хэрлэн суманд услалтын систем шинээр байгуулна.	-	гүйцэтгэлийн хувиар	Зураг төсөл, ТЭЗҮ хийгдэж, гүйцэтгэгч шалгарсан.	Услалтын систем барих ажил эхэлнэ.	"Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 100 хувийн санхүүжилтээр Хэрлэн суманд 700 га-д услалтын систем шинээр байгуулах зураг төсөл хийгдэж, хашаажуулалтын ажлыг эхлүүлээд байна	100	100	
101	ЗДҮАХХАХТ 3.3.2.3. Стандартын шаардлага хангасан 50-100 тн багтаамжтай төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь барина.	-	тоогоор	2021 онд Мөрөн суманд 100тн зоорь барьсан.	2-оос доошгүй суманд зоорь барина.	"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт" төслийн 120.0 сая төгрөгийн хөрөнгөөр төмс, хүнсний ногоо хадгалах зоорь шинээр барих тендерт "ЭН БИ ЖИ" ХХК шалгарч Мөрөн суманд 100 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь шинээр барьж ашиглалтанд оруулсан. Хувийн хэвшлийн өөрийн хөрөнгө оруулалтаар Бэрх, Дархан суманд 50 тн багтаамжтай зоорийг тус тус барьж ашиглалтад оруулсан.	100	100	
<b>Зорилт 3.3.4. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулна.</b>									
102	ЗДҮАХХАХТ 3.3.4.2. Сумдын МЭТасагт лабораторийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.	-	тоогоор	-	6 сумын МЭТасагт дэмжлэг үзүүлсэн байна.	6 суманд 16.8 сая төгрөгөөр зөөврийн компьютер, бар код уншигч, хэвлэгч төхөөрөмж, мал тарилгын хашааны зардлыг шийдвэрлэсэн.	100	100	

103	ЗДҮАХХАХТ 3.3.4.3. Голомтлон гардаг 5 төрлийн халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, малаас хүнд халдварладаг халдварт, гоц халдварт өвчнүүдийн голомтуудыг жил бүр ариутгах ажлыг зохион байгуулна.	409.8	хувиар	2020 онд халдварт өвчний гаралт 47 голомтод байсан.	Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан байна.	2021 онд 3-н төрлийн халдварт өвчнийн голомт 21 бүртгэгдсэн бол 2022 онд 15-н голомтод бүртгэгдэж халдварт өвчний гаралт өмнөх жилээс 28.6 хувь буурсан байна.	70	100	
<b>Зорилт 3.3.5. Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ.</b>									
104	ЗДҮАХХАХТ 3.3.5.1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг тогтмол явуулах тоног төхөөрөмжөөр хангана.	10.0	хувиар	Жил бүр тогтмол зохион байгуулдаг.	Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажиллана.	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2 хөдөлгөөнт экспедици 14 удаа зохион байгуулж ажилласан. Хур тунадасыг 51,2%-иар нэмэгдүүлсэний дүнд зуншлагын байдал нийт нутгийн 87,3% нь сайн, 12,7%-д дунд зэрэг байсан. Бэлчээрийн зуны дээд ургац 2.8-19.4ц/га. 2020-2021 оны мөн үетэй харьцуулахад 1.2-9.6 ц/га-р илүү байна. Өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж 60 гаруй хувьд нөөцтэй болон хүрэлцээтэй, 40 орчим хувьд хэтэрсэн байна.	100	100	
105	ЗДҮАХХАХТ 3.3.5.2. Үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгуулж, бэлчээрийг хамгаална.	-	тоогоор	2021 онд 20.0 мянган га-д устгалын ажил хийгдсэн.	6 сумын 30.0 мянган га-д хийнэ	7 суманд малын тоо, толгойн албан татварын 42.2 сая төгрөгийн хөрөнгөөр 25.2 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной тэмцэх, Баянхутаг сум малын тоо, толгойн албан татварын 6.0 сая төгрөгийн хөрөнгөөр 500 га бэлчээрт царцаатай тэмцэх арга хэмжээг технологийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтан дор зохион байгуулж ажилласан.	100	100	
106	ЗДҮАХХАХТ 3.3.5.3. Тал хээрийн бүсийн сумдад инженерийн хийцтэй худаг, хөв цөөрөм бий болгоно.	57.4	тоогоор	2021 онд 49 инженерийн хийцтэй худаг гаргасан.	5-аас доошгүй инженерийн хийцтэй худаг гаргаж, хөв цөөрөм байгуулна.	Энэ онд 8 суманд орон нутгийн төсвийн 347.0 сая төгрөгийн хөрөнгөөр 20 гүн өрмийн худаг, малчдын санаачилгаар 14 суманд 340.0 сая төгрөгийн хөрөнгөөр 34 гүн өрмийн худаг, төсөл хөтөлбөрийн 192,0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 гүн өрмийн худаг, нийт 60 худаг шинээр гаргаж 90.0 мянган га бэлчээрийг усжуулсан.	100	100	
<b>Зорилт 3.3.6. Гарааны бизнес эрхлэгчид, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувийн хэвшлийн санал санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлнэ.</b>									
107	ЗДҮАХХАХТ 3.3.6.1. Чингис хот дахь гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах "Бизнес инкубатор төв"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	-	тоогоор	6 үйлдвэрийн 20 ажлын байрыг бий болгосон.	4-с доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулна.	Мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, утсан тахиа, алаг салат, кимчи үйлдвэрлэх цех, хэрчсэн гурил, талхны цех 2, ааруул цагаан идээ боловсруулах цех, ноос ноолууран хувцас үйлдвэрлэл зэрэг 6 бойжигчийг бойжуулахаар хамтран ажиллах гэрээ хийж 3 ажлын байрыг шинээр бий болгоод байна.	70	100	

108	ЗДҮАХХАХТ 3.3.6.2 "Хэнтийн намрын ногоон өдрүүд", "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.	5.5	хувиар	2021 онд Цагаан сар-Цагаан идээ үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаагүй. Хэнтий намрын баярт 10 сумын үйлдвэрлэгчдийг хамруулан зохион байгуулсан.	18 сум, 5 тосгоны үйлдвэрлэгчдийг хамруулна.	"Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдаа сум тус бүрт зохион байгуулж 18 сумын 143 иргэн, 34 аж ахуйн нэгж оролцож, 370.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. "Хэнтийн намрын баяр - 2022" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 18 сум, 5 тосгоны 123 иргэн, 40 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл, 8 хоршоод 270 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 55.0 сая төгрөгийн борлуулалт хийж төв суурин газрын хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нөөцлөх худалдан авах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.	100	100
109	ЗДҮАХХАХТ 3.3.6.3. Төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авах ажлыг зохион байгуулна.	-	хувиар	2021 онд төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн ААН-ийн хоол үйлдвэрлэлд 613,7 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авсан.	Дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хэмжээг нэмэгдүүлж, борлуулалтыг сайжруулна.	Хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэл эрхлэгч 64 аж ахуйн нэгжээс Бор-Өндөр сум болон Бэрх тосгонд үйл ажиллагаа явуулдаг 5 уурхайд 32.0 сая төгрөгийн хүнсний ногоо, 18 сум, 5 тосгоны 23 сургууль, 21 цэцэрлэг, 1 яслийн үдийн цайнд 606.2 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 18 сумын ЭМТөвд 540.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, аймгийн ШШГГазарт 55.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, нийт 1.2 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг тус тус нийлүүлээд байна.	70	100

110	ЗДҮАХХАХТ 3.3.6.4. Хаврын улиралд шаардлагатай махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжид урамшуулал олгох замаар махны үнийн тогтвортой байдлыг хадгална.	50.0	тоогоор	2021 онд 33 тн маханд нөөцийн урамшуулал олгосон.	60 тн-оос багагүй махны нөөц бүрдүүлж, үнийн тогтвортой байдлыг хадгалсан байна.	Түшиглэг хөгжөөнд 8 аж ахуйн нэгж ажилласныг зориулалттай өртөг, дотоодын нөөцөд 2 аж ахуйн нэгж 100тн мах нөөцөлсөн байна. Нөөцийн махыг зах зээлийн үнээс хямд үнээр худалдаалах аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалт зарлаж, "Дээдсийн сүрэг" ХХК шалгарсан, Тус аж ахуйн нэгж нь Чингис хотод үйл ажиллагаа явуулж буй 12 хүнсний дэлгүүртэй хамтран ажиллаж төв суурин газрын айл өрхөд зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн хямд үнээр хонины мах 20тн, үхрийн мах 10.9тн нийт 30.9тн нөөцийн мах нийлүүлсэн. Аймгийн Засаг даргын нөөц сангийн 50 сая төгрөгийн үнийн хөнгөлөлтийн урамшуулал олгосон.	100	90
111	ЗДҮАХХАХТ 3.3.6.5. Анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжинэ.	-	тоогоор	2021 онд 4 аж ахуйн нэгж, 49 иргэнд 573.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	5-с доошгүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, 15-с доошгүй ажлын байр бий болгосон байна.	1. Баян-Овоо суманд "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мал төхөөрөх цогцолбор"-ыг шинээр барьж хоршоонд хариуцуулахаар ажиллаж байна. 2. Мөрөн, Биндэр сумдад европын холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах нь "ИМПАКТ" төслийн 100 хувийн санхүүжилтээр түүхий эдийн агуулах шинээр барьж, Биндэр сумын "Өгөөж баян Биндэръяа", Мөрөн сумын "Мөнх мандах Мөрөн" хоршоонд тус тус хүлээлгэн өгсөн. 3. Биндэр суманд 16*9 хэмжээтэй түүхий эдийн агуулах 44 сая төгрөг, Мөрөн суманд 12*8 хэмжээтэй түүхий эдийн агуулахыг 37 сая төгрөг, нийт 81 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлээд байна. Мөн тус 2 хоршоонд төслийн 100 хувийн санхүүжилтээр 72 ширхэг Галшар үйлдрийн ухна хүлээлгэн өгснөөр нийт 15 ажлын байрыг бий болгоод байна. 4. Дадал суманд ХХСангаас 2 хоршоо, 1 иргэнд 45 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 10 ажлын байр хадгалагдан үлдэж, шинээр 11 ажлын байрыг нэмэгдүүлсэн. 5. Өмнөдэлгэр суманд ЖДҮХСангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 8 аж ахуй нэгжид 880.000.000 төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдэгдээд байна. Тухайн төслүүд дэмжигдсэнээр шинээр 25 ажлын байрыг нэмэгдүүлнэ.	50	100
<b>Түүхэн аялал жуулчлал хөгжил</b>								
<b>Зорилго 3.4. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг хэрэгжүүлж, Түүхэн аялал жуулчлал, үндэсний онцлог шингэсэн арга хэмжээнүүдийг сурталчилна.</b>								
<b>Зорилт 3.4.1. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуух сумдад байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд /өрх/-ийг түшиглэсэн тогтвортой, эко аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.</b>								

112	ЗДҮАХХАХТ 3.4.1.1 Нутгийн брэнд, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулж, тогтвортой, эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4.0	хувиар	Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ААН 13 хувиар нэмэгдсэн.	Шинээр аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 2-оос доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	2022 онд 3 удаагийн сургалтанд 72 бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хамрагдаж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийн тоо өмнөх оноос 12%, аж ахуйн нэгж 9.7%-аар тус тус нэмэгдсэн.	100	100	
<b>Зорилт 3.4.2. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх, орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг 30 хувиар нэмэгдүүлнэ.</b>									
113	ЗДҮАХХАХТ 3.4.2.1 Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд болон ААН-үүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх санал санаачлагыг дэмжиж, ногоон санхүүжилт, бусад хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулна.	-	хувиар	Ажлын байрыг 7.4 хувиар нэмэгдүүлсэн	Ажлын байрыг 5 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Гурван голын нүүдэлчид" аялал жуулчлалын холбооны Тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдийн хамт Хаан банкны удирдлагатай уулзаж, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх ногоон зээлийн үйлчилгээнд хамтран ажиллах зорилгоор уулзалтыг хийж одоогийн байдлаар 2 аж ахуй нэгж материалаа өгч судлуулж байна. 2020 онд байнгын болон түр ажлын байр 808 байсан бол 2021 онд ажлын байр 868, 2022 онд 891 болж 10.2 хувиар нэмэгдсэн байна.	100	100	
<b>Зорилт 3.4.3. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Мянганы суут хүн Чингис хаан" цогцолборуудын ажлыг /Дадал сум "Чингис хаан", Биндэр сум "Их Хуралдай", Батноров сум "Хүлэг Боорчи-Андлалын өргөө", Норовлин сум "Шихихутаг-Их засаг", Бэрх тосгон "Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв", Дэлгэрхаан сум "Монголын нууц товчоо"/ дуусгаж, дэд бүтцээр холбох ажлыг эхлүүлнэ.</b>									
114	ЗДҮАХХАХТ 3.4.3.1 "Мянганы суут хүн Чингис хаан" цогцолборуудын ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллана.	УТХО-16769.6	Гүйцэтгэлийн хувиар	6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 70%	6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 80%-д хүрсэн байна.	Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд баригдаж буй цогцолборуудын ажлын явц 75 хувьтай үргэлжилж байна. Биндэр суманд баригдаж буй Их хуралдай цогцолборын гадна болон интерьерийн ажил дууссан. "Шихихутаг-Их засаг" цогцолборын Барилга угсралтын ажил 70%, гадна инженерийн шугам сүлжээний ажил 100%, гадна тохижилт 50%, дотор интерьерийн ажил 20%-тай тус тус үргэлжилж байна. "Монголын нууц товчоо" цогцолборын Барилга угсралтын ажил 60%-тай цогцолборын гадна цахилгаан хангамжийн ажлыг "АЭБОО" ХХК гүйцэтгэж ажил 70%-тай хэвийн үргэлжилж байна. Мөн цогцолборын интерьер, гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Ди Эс Ти" ХХК шалгарч 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан барилгын ажлыг хийж байна. Түүхэн цогцолборуудыг ашиглалтанд оруулах бэлтгэл ажлыг хангаж, дэд бүтцэд холбох ажлууд хийгдэж байгаа бөгөөд холбогдох газруудтай хамтран тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	96	100	



Зорилт 3.4.4. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна.								
115	ЗДҮАХХАХТ 3.4.4.1 Дэлгэрхаан, Батноров, Өмнөдэлгэр, Норовлин сумдад түр буудаллах цэгүүд барьж, Хэрлэн суманд аялал жуулчлалын мэдээллийн төвтэй байгуулж ашиглалтад оруулна.	-	төсөл хэрэгжсэн эсэх	Хэрлэн суманд аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулсан.	Өмнөдэлгэр суманд түр буудаллах цэг байгуулна	Өмнөдэлгэр суманд түр буудаллах цэг байгуулахаар төлөвлөж 2021 онд зураг төсөв хийлгэж батлуулсан бөгөөд тухайн зураг төсвийн дагуу түр буудаллах цэг байгуулах саналыг хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн боловч санал ирүүлээгүй, харин улсын чанартай автозамын трассын дагуу Жаргалтхаан суманд түр буудаллах цэг байгуулах саналыг "Исун мод түр" ХХК-аас ирүүлж, орон нутагтай хамтран ажиллаж "Өртөө 240" түр буудаллах цэгийг барьж ашиглалтад оруулан 10 орчим иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.	100	90
Зорилт 3.4.5. "Монгол хатад", "Ёохор наадаан", "Чингис фестиваль", "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийн цар хүрээг өргөжүүлэн тогтмол зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.								
116	ЗДҮАХХАХТ 3.4.5.1 "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийг жил бүр тогтмол зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	9.0	арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	2021 онд 4 арга хэмжээг зохион байгуулсан.	+	Хэнтий аймгийн хэмжээнд албан ёсны бүртгэлтэй 6 эвент арга хэмжээ зохион байгуулагддаг. Энэ онд зохион байгуулсан Тогорууны баярт гадаад 20, дотоод 500 гаруй, 5 тур оператор оролцсон. Талын тайга нохойн эвент арга хэмжээнд 600 орчим, Галшар адууны баярт 400 орчим дотоодын үзэгчид оролцож, эвентийг үзэж сонирхсон байна. Батноров суманд Талын түмэн адуу эвент арга хэмжээ зохион байгуулагдаж 40 гаруй гадаад, 1500 гаруй дотоодын жуулчид, иргэд оролцсон.	100	100
Зорилт 3.4.6. Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.								
181	ЗДҮАХХАХТ 4.3.14.4 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран хугацаат цэргийн албанаас халагдсан иргэдийг нийгмийн суурь судалгаанд хамруулна.	-	Судалгаанд хамрагдсан %-иар	50%	60%	Жил бүрийн ээлжит цэрэг татлагаар хугацаат цэргийн албанаас халагдан ирж байгаа залуучуудыг хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газартай хамтран нийгмийн холбогдох судалгаанд хамруулж ажиллаж хэвшсэн.	90	90
<b>Зорилт 4.3.15. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлэх, сэдэвчилсэн сургалт зохион байгуулна.</b>								
182	ЗДҮАХХАХТ 4.3.15.1 Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх талаар санал бэлтгэн аймаг, сумдын төсөвт суулгах	-	Нөөц бүрдүүлэлт %-иар	20%	40%	Сумдын Засаг дарга нарт албан бичгээр Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай нөөц бүрдүүлэлт хийх, орон нутгийн төсөвт шаардлагатай зардлыг оруулах талаар чиглэл өгч ажилласаны үр дүнд 18 сум, 4 тосгонд нөөц бүрдүүлэн ажиллаж байна.	90	100
183	ЗДҮАХХАХТ 4.3.15.2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бие бүрэлдэхүүний тодотголыг тогтоосон хугацаанд хийж нөхөн томилгоожуулах	-	-	2021 оны 5, 11 дүгээр саруудад явуулж томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх боломжийг бүрэн хангаж ажилласан.	Тогтоосон хугацаанд тодотголыг хийж хэвшсэн байна.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бие бүрэлдэхүүний тодотголыг хүн, хүч техникийг татан оролцуулах бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор 2 дугаар сард бүрэн хэмжээний тодотгол хийсэн.	100	100
184	ЗДҮАХХАХТ 4.3.15.3. Томилгоот нэгжүүдийн сургалтыг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулах	3,0 сая	-	Сумдыг бүсчлэн хувааж жил бүр хийж хэвшүүлэх	Төлөвлөгөөний дагуу сургалт хийгддэг болсон байна.	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, 2022 оны цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөө, Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны А/597 дугаар захирамжийн дагуу "Орон нутгийн хамгаалалт"-ын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалт, дадлагыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Баян-Овоо, Хэрлэн суманд зохион байгуулж явууллаа.	90	100
<b>Зорилт 4.3.16. Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөний дагуу албан байгууллага, иргэдийг даалгаваржуулж, тогтоосон хугацаанд тодотголыг явуулна.</b>								

185	ЗДҮАХХАХТ 4.3.16.1 Улсын болон цэргийн дайчилгааны даалгаврын дагуу төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах	-	-	Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж ЗХЖШ-ын даргаар батлуулж орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна.	50%	Цэргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж ЗХЖШ-ын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Улсын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан холбогдох мэдээ, судалгааг гарган ажиллаж байна.	100	100
186	ЗДҮАХХАХТ 4.3.16.2 Улсын болон цэргийн дайчилгааны даалгаварын дагуу иргэд, эд хөрөнгө, албан байгууллагыг оногдуулан данслаж, даалгаваржуулах	-	даалгаваржуулж дансалсан байдал %-иар	30%	50%	ЗХЖШ-аас ирүүлсэн дайчилгааны даалгаварын дагуу бэлтгэл офицер, 1-р зэргийн үүрэгтэн, авто техникийг сумдад хуваарилан оногдуулан бүртгэсэн. Сумын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг шинээр боловсруулах албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, заавар зөвлөгөө өгч, цэргийн штабын дарга, офицеруудаар хянуулан, аймгийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах газрын даргаар батлуулж, 2022 оны 10 дугаар сард хүлээлгэн өгч хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд хүн, техникийн тодотголыг хийн ажиллаж байна.	100	100
<b>Зорилт 4.3.17. Цэргийн бүртгэлийн цахим системийг нэвтрүүлж, сумдыг холбоно.</b>								

187	ЗДҮАХХАХТ 4.3.17.1 Цэргийн бүртгэлийн цахим системийг мэргэжлийн байгууллагаас захиалан авах, цэргийн үүрэгтний мэдээллийг нэг бүрчлэн оруулж албан хэрэглээнд ашиглах	2.5 сая	-	Цэргийн бүртгэлийн цахим системийг мэргэжлийн байгууллагаас захиалан авч, холбогдох компьютер, техник хэрэгслийг бүрэн авч цэргийн үүрэгтний мэдээллийг нэг бүрчлэн оруулах ажил явагдаж байна.	Цэргийн бүртгэлийн цахим программыг суурилуулж үйл ажиллагаандаа 100% ашиглана.	Цэргийн бүртгэлийн цахим системийг мэргэжлийн байгууллагаас захиалан авч, цэргийн үүрэгтний мэдээллийг нэг бүрчлэн оруулах ажил 80 хувьтай явагдаж байна.	80	90	
188	ЗДҮАХХАХТ 4.3.17.2 Сумдын ЗДТГ-тай онлайн холболт хийж, иргэн, цэргийн үүрэгтний, шилжилт хөдөлгөөн зэрэг мэдээллийг шуурхай солилцох	0.5 сая	-	E-Mongolia аппликэйшин ыг ашиглан сумдын ЗДТГ-тай групп чат үүсгэн холбогдох мэдээллийг шуурхай солилцон ажиллаж байна.	Онлайнаар 60% холбогдох	E-Mongolia аппликэйшин болон бусад онлайн сүлжээг ашиглан сумдын ЗДТГ-тай групп чат үүсгэн холбогдох мэдээллийг 100 хувь шуурхай солилцон ажиллаж байна.	80	100	
Зорилт 4.3.18. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн Политехник коллежид “Оюутан-Цэрэг” сургалтыг зохион байгуулна.									
189	ЗДҮАХХАХТ 4.3.18.1 Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулиудад “Дайчин алдар”-ын булан байгуулах ажлыг үргэлжлүүлэх	0.3 сая	Хийгдсэн хувиар	60%	70%	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-уудыг 100% дайчин алдарын булантай болгосон.	100	100	

190	ЗДҮАХХАХТ 4.3.18.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Цэрэгжлийн спортын "Дөл" тэмцээнийг жил бүр зохион байгуулж, улсын аваргад оролцох	5.0 сая	-	12 сард зохион байгуулсан.	+	Цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээнийг 05 дугаар сарын 21,22-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар БХ-ын сайдын нэрэмжит Цэрэг-спортын "ДӨЛ" Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож нийт 38 багаас 15 дугаарт орсон амжилт гаргасан.	100	100
191	ЗДҮАХХАХТ 4.3.18.3. Политехник коллежд цэрэгжлийн танхим байгуулах, "Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт"-д хамруулах	1.0 сая	-	5%	10%	2022 онд Хэнтий аймгийн Политехникийн коллежоос "Оюутан-цэрэг сургалт"-т Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар 10 оюутан, сурагчийг хамруулахаар болсон боловч 2022 онд орон нутгаас хамруулахгүй болсон тухай Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Хэнтий аймгаас хамруулаагүй хойшлогдсон болно.	50	100
<b>ТАВ. НОГООН ХӨГЖИЛ</b>								
<b>Цэвэр орчин-ногоон бүс</b>								
<b>Зорилго 5.1. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулж нөхөн сэргээх.</b>								
<b>Зорилт 5.1.1. Чингис хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.</b>								
192	ЗДҮАХХАХТ 5.1.1.1 Чингис хотын агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам батлуулж, агаарын бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	-	хэрэгжилтийн хувиар	Агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам боловсруулсан.	Агаарын бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргын 2022 оны А/492/А/557 дугаар хамтарсан шийдвэрээр Чингис хотын агаарын чанарын 1, 2 дугаар бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг баталсан. Журмын дагуу бүс тус бүрд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан ба хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.	100	100
193	ЗДҮАХХАХТ 5.1.1.2 Чингис хотын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хөрсний бохирдлыг бууруулна.	20.0	хэрэгжилтийн хувиар	Чингис хотын хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулсан.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 20 хувь хангагдаж, хөрсний бохирдол буурсан байна.	Аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг "Өнгө нэм" ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж төслийг холбогдох байгууллагууд, сумдад хүргүүлж санал авч, ажлын хэсгээр хэлэлцүүлж, 12 дугаар сарын 05-нд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлууллаа. Аймгийн төвийн ил задгай хог хаягдлыг 2 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээгээр цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах ажлыг зохион байгуулснаар, 3600 га газрын хөрсний бохирдлыг буурууллаа.	100	50

194	ЗДҮАХХАХТ 5.1.1.3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого зохион байгуулж, агаарын чанарын мониторинг хяналтыг тогтмолжуулна.	2.0	хэрэгжилтээр	Жил бүр хийгдэж, суурь мэдээллийн сан бий болсон.	Тооллогын ажил зохион байгуулагдаж, үр дүнд анализ хийгдсэн байна.	2022 оны агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 18 сум 5 тосгоны хэмжээнд зохион байгуулж нэгтгэл үр дүнг хуулийн хугацаанд багтаан БОАЖЯаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 7024 айл өрх тоологдсоноос ердийн галлагаатай айл өрх 6007 /89%/, сайжруулсан зуухтай айл өрх 1017 /11%/ байна. Мөн байшингийн ердийн галлагаатай зуухтай айл 81%, сайжруулсан зуухтай айл өрх 19% эзэлж байна. Хүчин чадлаар ангилбал 4200кВт -2, 100-4200кВт зуух 34, 15-100кВт зуух 3335 зуух тоологдсон. Сумын төвүүд төвлөрсөн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэцэд холбогдсон тул 15-100кВт зуухны тоо 23%-иар буурсан үзүүлэлттэй байна.	100	100
Зорилт 5.1.2. Шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлж, "Эко өрх", "Өрх бүр ногоон төгөл" аяныг өрнүүлж гэр хорооллын айл өрхүүдийн 50 хүртэл хувийг хамруулснаар агаар хөрсний бохирдлыг тус тус 30 хүртэл хувиар бууруулна.								
195	ЗДҮАХХАХТ 5.1.2.1 "Эко өрх", "Өрх бүр ногоон төгөл" аяны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	хувиар	нийт өрхийн 20 хүртэл хувийг аянд хамруулсан.	нийт өрхийн 20-аас доошгүй хувийг аянд хамруулна.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд "Өрх бүр ногоон төгөл" аяныг сум бүрт зохион байгуулахыг уриалж, нийт гэр хорооллын өрхийн 28 хувь болох 3418 айл өрх хашаандаа 10.0 мянга гаруй мод бут тарьж оролцсон байна. Хэрлэн сумын хэмжээнд "Эко өрх" аяныг өрнүүлж, хашаандаа мод бут, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьсан, хог хаягдлаа ангилсан зэрэг шалгуураар "Эко өрх" шошгыг 170 өрхөд гардуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.	100	100
196	ЗДҮАХХАХТ 5.1.2.2 Шахмал түлш үйлдвэрлэх, худалдаалах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санал санаачлагыг дэмжиж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулна.	-	хэрэгжилтээр	3 суманд тоног төхөөрөмж нийлүүлсэн.	Шахмал түлшийг борлуулах, худалдаалах цэг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн байна.	Батширээт, Өмнөдэлгэр, Биндэр сумдын ЗДТГ-аас тус бүр 1 албан хаагчийг Сэлэнгэ аймагт шахмал түлшний зуухыг ажиллуулах чиглэлээр туршлага судлуулсан. Налайх дүүрэгт үйлдвэрлэгдэж буй шахмал түлш нь одоогоор УБ хотын гэр хорооллын айл өрхийн хэрэглээг дөнгөж хангахуйц хүчин чадалтай ажиллаж байгаа тул орон нутаг руу нийлүүлэх, худалдах борлуулах цэг байгуулах боломжгүй талаар хариу ирсэн.	70	50
Зорилт 5.1.3. Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төвлөрсөн хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээг 40 хүртэл хувиар бууруулна.								

197	ЗДҮАХХАХТ 5.1.3.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлэх, сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажлуудыг жил бүр зохион байгуулна.	2.0	тоогоор	Сургалт, нөлөөллийн ажлыг сар бүр зохион байгуулсан.	Сургалт, нөлөөллийн ажлыг 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.	Сумдын Засаг дарга, БОХУБ нарт Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран хог хаягдлын менежментийн 5 модуль сургалтыг зохион байгуулсан. 3 суманд "Эко хот-эрүүл орчин" аян зарлаж айл өрхүүдийн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж, модны суулгац, хүнсний ногооны үр үрсэлгээгээр солих "Хогоо мод болгоё" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 700 гаруй өрх хамрагдаж дахин боловсруулах боломжтой нийлэг уут, хуванцар сав, лааз, шил, цаас, баттерей зэрэг 3 тонн орчим хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулсан. Мөн ЕБС-ын сурагчдын дунд "Аюулыг авдарлая" сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 313ш сав буюу 117375 ширхэг тамхины ишийг цуглуулж устгасан.	100	100
198	ЗДҮАХХАХТ 5.1.3.2. Сумдад хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана	80,0	тоо, хувиар	3 суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн	2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, дахивар хог хаягдлын хэмжээ 20 хүртэл хувиар буурсан байна.	Баян-Адрага сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор "Дахивар хог хаягдал цуглуулах цэг" байгуулаад байна. Мөн Дархан сум хог хаягдал пресслэгч тоног төхөөрөмж, Дэлгэрхаан сум хог тээврийн автомашин шинээр авсан. ТАЖХТөслийн санхүүжилтээр Дадал суманд 2-р зэрэглэлийн ландфилл цэг байгуулагдаж байна. Баянмөнх сум хуучин хогийн цэгийг дарж булшлан шинээр ландфил хогийн цэг бий болгосон. Баялаг хурах ХХК нь 10тн хуванцар, 1тн лаазыг ТМЛ ХХК-ын үйлдвэрт, 3тн гялгар уутыг Пластик центр ХХК-д тушаагаад байна. АПУ ХХК 50000ш буюу 22.2тн архи пивоны шилийг буцаан авч дахин ашигласан. Энэ нь 2021 оны хог хаягдлын бүтцийн судалгаатай харьцуулахад нийт дахивар хог хаягдлын 19.3 хувийг эзэлж байна.	100	100
<b>Зорилт 5.1.4. Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ.</b>								
199	ЗДҮАХХАХТ 5.1.4.1 "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг жил бүр зохион байгуулж, аймгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг 20 га талбайгаар нэмэгдүүлж нийт 65 га-д хүргэнэ.	600,0	нэмэгдсэн га талбайн хэмжээгээр	Аймгийн нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 51 га	15000 ш мод тарьж ногоон байгууламжийн талбайн хэмжээг 5 га - аар нэмэгдүүлнэ.	Хавар, намрын "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн хүрээнд аймгийн хэмжээнд төв суурин газарт нийт 148.7 мянган мод таригдаж, ногоон байгууламжийн хэмжээ 29.5 га талбайгаар нэмэгдсэн. Дээрх ажилд давхардсан тоогоор 20.5 мян иргэн, 905 ААН, байгууллага 3418 өрх хамрагдаж, 595 хүнийг түр ажлын байраар хангаж ажилласан.	100	100
200	ЗДҮАХХАХТ 5.1.4.2 Чингис хотын нийтийн эзэмшлийн талбайд зүлэгжүүлэлт хийж хөл газрын ургамлын талбайн хэмжээг бууруулж, ногоон байгууламжид арчилгаа хийнэ.	20.0	га талбайн хэмжээгээр	2021 онд 0.3 га талбайг зүлэгжүүлсэн	Нийтийн эзэмшлийн 1 га талбайд зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийг арчилна.	Чингис хотын нэгдсэн эмнэлэгийн урдуур байрлах явган хүний зам дээгүүрх 0.05 га, олимп цогцолборын хойд талаас Эрдэнэ буудал хүртэл Нарс тарьсан хайсны 0.06 га, Чойномын хөшөөтэй гэрэлт гудамжны 0.8 га нийт 0.9 га талбайн хөл газрын ургамлыг устгаж, ногоон байгууламжийн арчилгааг хийсэн.	90	90

Зорилт 5.1.5. Аймгийн хэмжээнд 1000 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, нийт ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 0.05 хувиар нэмэгдүүлнэ.								
201	ЗДҮАХХАХТ 5.1.5.1. Жил бүр ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ	75.0	га талбайн хэмжээгээр	Ойжуулалтын ажлыг 124 га талбайд хийсэн.	Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 250 га талбайд хийнэ.	Аймгийн хэмжээнд нийт 222.5га талбайд ойжуулалт хийгдэж, 442.6 мянган ширхэг нарс, шинэсний тарьц таригдсан байна. Дээрх ажилд 21 ААН оролцож, 211 хүнийг түр ажлын байраар хангасан.	100	100
202	ЗДҮАХХАХТ 5.1.5.2. Ойн хөнөөлт шавжийн идэвхжилээс шалтгаалан голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд нь тэмцлийн ажлыг зохион байгуулж ойг доройтлоос хамгаална.	20.0	хэрэгжилтээр	Ойн хөнөөлт шавжийн судалгаа хийсэн	Тухайн жилийн голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд тэмцлийн ажлыг зохион байгуулна.	Улсын төсвийн хөрөнгөөр "Ойн судалгаа хөгжлийн төв" УТҮГ-аар хийлгэсэн 2021 онд намрын судалгаагаар ойн хөнөөлт шавж 5187га-д тархалттай, 3378 га-д ойн хөнөөлт шавжийн голомттой гэсэн дүн гарсан. Цэнхэрмандал сумын Хөх нуур нэртэй газарт 376га талбайд Цэнхэрмандал сумын ойн анги орон нутгийн төсвийн хөрөнгийн БХНСАХЗ-аар, Биндэр сумын 1500га талбайд Биндэр-Ой СДОА өөрийн хөрөнгөөр Яковсоны төөлүүрч эрвээхэйн тэмцлийн ажлыг хийж гүйцэтгэсэнээр нийт голомттой талбайн 55.5%-д тэмцлийн ажлыг хийлээ.	100	100
Зорилт 5.1.6. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, түүний ай сав газар, ховор ан амьтан, ургамлын тархац нөөц бүхий байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах, экосистемийн ач холбогдол бүхий газруудыг улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, нийт нутаг дэвсгэрийн 47 хувьд хүргэнэ.								
203	ЗДҮАХХАХТ 5.1.6.1. Усны ай сав бүхий болон экосистемийн ач холбогдол бүхий газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авна	13.5	хувиар	44.8	45	Улсын тусгай хамгаалалттай 9 газрын 1071460 га, орон нутгийн хамгаалалттай 452 газрын 2513846,4 га, нийт 461 газрын 3585306,4 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 44,6 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна. Өмнөдэлгэр сумын Тэнүүн гол орчмын газрыг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авах судалгааны ажил хийгдэж байна.	100	100
Зорилт 5.1.7. Амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх, зохистой ашиглах менежмент зохион байгуулалтыг хийж, ховор амьтдын тоо толгойг 3 хүртэл хувиар өсгөнө.								
204	ЗДҮАХХАХТ 5.1.7.1 Ховор, нэн ховор амьтдыг хамгаалах, идэш тэжээлээр хангах био техникийн арга хэмжээ авна.	3.0	тоогоор	11 суманд био техникийн арга хэмжээ авсан.	Жилд 4-өөс доошгүй суманд био техникийн арга хэмжээ авсан байна.	Дархан сумын Дархан ан нөхөрлөл, Бор-Өндөр сумын 6-р багийн малчин Г.Далайбаяр нартай гэрээ байгуулж нэн ховор, ховор амьтад нутагладаг 2 сумын 8 газарт байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын 3.0 сая төгрөгөөр 200 боодол өвс, 8тн хужир шүүг тавьж биотехникийн арга хэмжээ авч амьтны нөөцийг өсч үржих боломжоор хангаж байна.	100	70



205	ЗДҮАХХАХТ 5.1.7.2. Амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх зорилгоор агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	23.0	тоогоор	14 агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө хийгдсэн.	Жил бүр 1-ээс доошгүй агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна.	Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнтэй гэрээ байгуулж Өмнөдэлгэр сумын Элгэнжаргалант агнуурын бус нутагт нарийвчилсан агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөөг хийлгүүлж сумын ИТХ-ын 2022 оны А/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн. "Эко-Үйлчилгээ" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт менежмент төлөвлөгөөг хийлгэж хүлээж авч байна. Монголын анчдын нийгэмлэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж Хэнтий аймгийн хэмжээнд Монгол тарваганы нарийвчилсан агнуур зохион байгуулалт менежмент төлөвлөгөөг хийлгээд байна.	100	100	
<b>Зорилт 5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаална.</b>									
206	ЗДҮАХХАХТ 5.1.8.1 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 120-оос доошгүй тэмдэг тэмдэгжүүлэлт хийнэ.	20.0	тоогоор	Усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсээр 66 тэмдэг байршуулсан.	30-аас доошгүй тэмдэгжүүлэлт хийгдсэн байна.	Баянмөнх, Баянхутаг сумдын нутаг дэвсгэрт Хэрлэн голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг сурталчилан, таниулах 50 ширхэг тэмдэг байршуулж, орон нутагт хүлээлгэн өгсөн.	100	100	
207	ЗДҮАХХАХТ 5.1.8.2 Шаардлагатай булаг шандны эхийг хашаажуулах, сэргээн засах ажлыг зохион байгуулна.	34.0	тоогоор	22 булгийн эхийг хашиж хамгаалсан.	20-оос доошгүй булгийн эхийг хашиж, сэргээн зассан байна.	Хэрлэн голын сав газарт хамаарах сумдад 10 булаг, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах сумдад 5, Онон-Улз голын сав газарт хамаарагдах 3 суманд 5, нийт 20 булгийн эхийг хашиж, хашааг сэргээн засаж хамгаалсан.	100	100	
<b>Зорилт 5.1.9. Элэгдэл, эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газар, түүний хэвлийд техникийн нөхөн сэргээлт ажлыг 80 га газарт хийнэ.</b>									
208	ЗДҮАХХАХТ 5.1.9.1. Эзэнгүй орхигдсон газрын хэвлийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулна.	50.0	га талбайн хэмжээгээр	11.3 га газарт нөхөн сэргээлт хийсэн.	Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн орхигдсон 20 га-талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.	2022 онд 48.3 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Орон нутгийн төсвийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдрэлд орсон 10га талбайг 10 сая төгрөгийн өртгөөр "Шижир тэмүүлэл" ХХК, Бор-Өндөр суманд хууль бус жонш олборлолтоос үсч эвдрэлд орсон 10га талбайг 20 сая төгрөгийн өртгөөр "Итгэлт буман эрдэнэ" ХХК, Баян-Адарга суманд хууль бус жонш олборлолтоос үсч эвдрэлд орсон 10га талбайг 20 сая төгрөгийн өртгөөр "Адарга тохижилт" ОНӨҮГазар тус тус техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Бор-Өндөр суманд аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт 18.3га талбайд хийсэн.	100	100	

**ЗУРГАА. АЙМГИЙН ТӨВ, СУМ ТОСГОДЫН ХӨГЖИЛ**

**6.1 Чингис хот**

**Зорилт 6.1.1. Дулааны станцын гадна инженерийн хангамжийн ажлыг гүйцэтгүүлнэ.**

209	ЗДҮАХХАХТ 6.1.1.1 Дулааны станцыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангагдана.	100.0	Ажлын гүйцэтгэлээр	Дулааны станцын "Гадна холбоо дохиололын зураг, төсөл магадлалаар хянагдсан. "УХАТ"-ын зураг төслийн гүйцэтгэгч гэрээ байгуулсан.	Дулааны станцын гадна инженерийн хангамжийн ажил эхэлнэ.	Дулааны станцын УХАТ-ын зураг төслийн гүйцэтгэгчээр "Гидродизайн инноваци" ХХК гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 70%, Дулааны станцын гадна цахилгаан хангамжийн зураг төслийг Мастерпойнт ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 70 хувьтай байна.	100	90
-----	---	-------	--------------------	---	--	---	-----	----

**Зорилт 6.1.2. Чингис хотын 2-р хэлхээний шугам сүлжээг үе шаттай гүйцэтгэнэ.**

210	ЗДҮАХХАХТ 6.1.2.1. 2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттай гүйцэтгэнэ.	1500.0	Ажлын гүйцэтгэлээр	2-р хэлхээний 3"р ээлжийн ажил эхэлсэн.	2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажил үргэлжилнэ.	Хэнтий-Ус ХХК-ний 3 болон 9-р зуух, Нямодо трейд ХХК-ийн уурын зуухны 2 хэлхээний шугам сүлжээ шинэчлэгдэж, зуухны тоноглол нэмэгдсэн.	100	100
-----	--	--------	--------------------	---	--	--	-----	-----

**Зорилт 6.1.4. Хэрлэн сумын 1 дүгээр багт хэрэгжиж байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг дуусгана.**

211	ЗДҮАХХАХТ 6.1.4.1. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.	2000.0	Барилгын ажил эхэлсэн эсэх	1-р багийн дахин төлөвлөлтийн хүрээнд гадна хангамжийн ажил бүрэн хийгдсэн.	Орон сууцны БУА-ыг эхлүүлнэ.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 90 айлын орон сууцны БУА эхлэх бэлтгэл ажил хангагдаж байна.	100	70
-----	---	--------	----------------------------	---	------------------------------	--	-----	----

**Зорилт 6.1.5. Чингис хотын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна.**

212	ЗДҮАХХАХТ 6.1.5.1 Чингис хотын гэр хорооллын худгуудад ухаалаг систем суурилуулж, төвлөрсөн цэвэр усны шугамд холбоно.	65	Ажлын гүйцэтгэлээр	Чингис хотын гэр хорооллын 1 худагт ухаалаг систем суурилуулсан	Чингис хотын гэр хорооллын 1 худагт ухаалаг систем суурилуулж төвлөрсөн цэвэр усны шугамд холбоно.	60.5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Баялаг Говь ХХК Хэрлэн сумын 2,3,4,5,6 дугаар багуудын 5 худгуудад ухаалаг систем суурилуулсан. Хэрлэн сумын 2 дугаар багт ухаалаг худаг, худгийн байр, төвлөрсөн шугамд холбох зураг төсөв бэлэн болсон.	100	100	
<b>Зорилт 6.1.6.Чингис хотод цэцэрлэгийн барилга-өргөтгөл 2, сургуулийн барилга-өргөтгөл 1, дотуур байрны барилга 2, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 1, спорт заал, талбай 2, соёлын төвийн барилга 1, залуучуудын сургалт, хөгжлийн төв 1, иргэдэд үйлчлэх төрийн байгууллагын барилга 4-ийг тус тус барьж байгуулна.</b>									
213	ЗДҮАХХАХТ 6.1.6.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу цэцэрлэг, дотуур барьж, өргөтгөл хийж, их засвар хийнэ	-	Тухайн жилийн хэрэгжилт хангагдсан эсэх	Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсан.	төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдсэн байна.	Хэрлэн 3 дугаар цэцэрлэгийн 200 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 87%-тай 1500 суудалтай 1-р сургуулийн барилга угсралтын ажил 98%-тай гүйцэтгэж байна. Тэмүүжин цогцолбор сургуулийн Дотуур байрны барилга угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй. Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын ажил 15%-тай, 5-р цэцэрлэгийн барилга 65%-тай үргэлжилж байна.	100	100	
<b>Зорилт 6.1.7. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зочид буудал, худалдааны төв, малын гаралтай түүхий эд болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, төвийн болон гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, хотын доторх хатуу хучилттай авто зам, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг гүйцэтгэнэ.</b>									
214	ЗДҮАХХАХТ 6.1.7.1 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зочид буудал, худалдааны төв байгуулах ажлыг дэмжиж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана.	-	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан тоогоор	-	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана.	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний санал авах ажлыг нээлттэй, хүртээмжтэй зохион байгуулан, хувийн хэвшлийн үйлчилгээний зориулалтаар газар эзэмших саналыг хүлээн авч 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажиллах чиглэлийг сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт хүргүүлсэн. Дадал суманд Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 19.89 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар төсөл сонгон шалгаруулах журмын дагуу эзэмшүүлж "Исун мод тур" ХХК барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. 2022 оны сумдын ГЗБайгуулалтын төлөвлөгөөнд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 40 нэгж талбар төлөвлөсөнөөс 18 нэгж талбар, 1.3 га газрыг эзэмшүүлээд байна.	100	100	

215	ЗДҮАХХАХТ 6.1.7.2. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулна.	-	Ажлын гүйцэтгэлээр	Хэрлэн суманд ноос угаах үйлдвэр шинээр ашиглалтанд орж Сүхбаатар, Хэнтий аймгийн малчдаас 800 тн ноос худалдан авч, анхан шатны боловсруулалт хийж угаан 70-80 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан.	ТЭЗҮ боловсруулна.	Жаргалтхаан суманд "Хаан хүнс импекс" ХХК Монгол улсад жишиг болсон 6.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, хоногт 100-200 бод, 400-600 бог төхөөрч, сард дунджаар 300 тонн мах болон дайвар бүтээгдэхүүн боловсруулж нөөцлөх хүчин чадал бүхий мах боловсруулах үйлдвэрийг шинээр барьж байна. Мөн Хэрлэн суманд "Цагаан чулуут" ХХК нь шинээр махны үйлдвэр байгуулж, ашиглалтанд оруулсан бөгөөд улирлын чанартай 35 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.	100	100
216	ЗДҮАХХАХТ 6.1.7.3 Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам сүлжээг байгуулна.	29500.0	Тухайн жилийн гүйцэтгэлээр	Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг төсөл магадлалаар хянагдсан.	Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил эхэлнэ.	Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станцын ажил удаашралтай, гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлж дулаан хангамжийн ажил 20%-тай бохир усны шугам сүлжээний ажил 80%-тай үргэлжилж байна.	100	100

217	ЗДҮАХХАХТ 6.1.7.4 Саарал усны технологийг нэвтрүүлж, хэрэглээнд оруулна.	100.0	-	Автомашин угаалгын газруудад саарал усны технологийг нэвтрүүлнэ.	Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа сумдын инженерийн байгууламж, бохир ус зайлуулах, цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлын төлөвлөлтөд саарал усны технологийг судлан нэвтрүүлэх бодлого барьж ажилласнаар бохир усыг 95-98%, цэвэрлэх технологи бүхий Чингис хотын 3000 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 2021 онд, Баямөнх суманд 50 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 2022 онд тус тус ашиглалтад орж, цэвэршүүлсэн саарал усыг мэргэжлийн хяналтын лаборатори авч шинжилгээнд хамруулан ашиглах боломжтой болж ногоон байгууламжинд ашиглаж эхэлээд байна. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 сум, 1 тосгонд ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн барилын ажил үргэлжилж байна.	90	100	
218	ЗДҮАХХАХТ 6.1.7.5 Чингис хотод цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.	-	-	Ашиглалтад орсон	95% хүртэл цэвэршүүлэх, 3000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон.	100	100	
219	ЗДҮАХХАХТ 6.1.7.6. Хотын доторх хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлнэ.	420.0	Ажлын гүйцэтгэлээр	2,5 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон.	Хотын доторх хатуу хучилттай авто замын ажил эхэлнэ.	4 замын уулзвараас Хэрлэн голын гүүр хүртэлх авто замын шинэчлэлт, Аймгийн төвийн автозамын засвар, шинэчлэлт, 3-р багийн автозам, явган замын өргөтгөл, шинчлэлтийн ажлууд бүрэн хийгдэж дууссан.	100	100
<b>6.2 Сум, тосгодын хөгжил</b>								
<b>Зорилт 6.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, сангийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.</b>								
220	ЗДҮАХХАХТ 6.2.1.1 Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулан сангийн үйл ажиллагааны үр дүнг жил бүр үнэлж дүгнэнэ.	-	үнэлгээний оноо	ОНХС-ийн тайлагналт хангалтгүй	ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэсэн байна.	ОНХС-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг 6 сум ирүүлснийг аймгийн Засаг даргад танилцуулж, бусад сумдыг яаралтай ирүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 2022 оны 06 сарын 03-ны 9/1418 тоот албан бичгээр хүргүүлсэн.	40	50
221	ЗДҮАХХАХТ 6.2.1.2 ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг сайжруулна.	-	тоогоор	2019 онд иргэдийн оролцоо 75 хувь	Иргэдийн оролцоог 80 хувьд хүргэнэ.	Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий төслийн хүрээнд Баян-Овоо сумын иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн туршлагыг солилцох, зөвлөлдөх уулзалт арга хэмжээг нийт сум, тосгодын Засаг дарга, Захирагч нарыг хамруулан зохион байгуулсан. Тус төслийн үр дүнд иргэдийн оролцооны хувь 92 хувьд хүрсэн байна.	70	100
<b>Зорилт 6.2.2. Төр, хувийн хэвшлийн дэмжлэгээр сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна.</b>								
222	ЗДҮАХХАХТ 6.2.2.1 Стандартын шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг сум, тосгодод шинээр барьж, ашиглалтад оруулна.	600.0	-	-	4-өөс доошгүй сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулна.	Баянмөнх болон Мөрөн суманд стандартын шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг барьж ашиглалтад оруулаад байгаа бөгөөд 18 хүнийг байнгын ажлын байраар хангаад байна. Мөн 3 суманд ашиглагдахгүй байсан хуучин захиргааны барилгыг ахуй үйлчилгээний төв болгон үйл ажиллагаа явуулж байна.	100	90

223	ЗДҮАХХАХТ 6.2.2.2 Нийтийн халуун усны төвгүй сум, тосгодоод халуун усны төв барина.	-	тоогоор	Норовлин суманд 1 халуун усны төв баригдсан.	2-оос доошгүй сумдад нийтийн халуун усны барилга барина.	Батноров сум ОНХС-аас 90.0 сая төгрөгний санхүүжилтээр шинэ халуун усыг барьж ашиглалтад оруулсан.	100	50
<b>Зорилт 6.2.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууцны барилга барих санал санаачилгыг дэмжинэ.</b>								
224	ЗДҮАХХАХТ 6.2.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж 500-аас доошгүй айлын орон сууц ашиглалтад оруулна.	-	Барилгын ажил эхэлсэн эсэх	-	500 -аас доошгүй айлын орон сууцны барилгын ажил эхэлнэ.	Хэнтий орон сууц ОНӨҮГ-ын захиалгаар барьж байгаа 60 айлын 3 блок орон сууцны барилга угрсалтын ажил 35%-тай байна. Хэрлэн сум 3 дугаар багт Хаан тауер 9 давхар 32 айлын орон сууцны барилга угрсалтын ажил 10%-тай үргэлжилж байна.	100	50
<b>Зоилт 6.2.4. Сумдын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна.</b>								
225	ЗДҮАХХАХТ 6.2.4.1 Сумдын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн усан хангамжид холбоно.	50.0	тоогоор	-	Төвлөрсөн усан хангамжийн системтэй сумдын худгийг холбох ажлыг эхлүүлнэ.	2022 онд шинээр ундны усны худаг Батширээт 2, Баян-Овоо 1, Хэрлэн 1 нийт 3 худаг гаргаад байна. Мөн хэрлэн сумын 2 дугаар багийн гэр хорооллын худгийг төвлөрсөн шугамд холбох ажлын зураг төсвийг хийлгэж 2023 оны төсөвт суулгаад байна.	100	90
226	ЗДҮАХХАХТ 6.2.4.2 Сумдын гэр хорооллын худгуудад ухаалаг систем суурилуулна.	50.0	тоогоор	3 сумын ус түгээх худаг ухаалаг системд холбогдсон.	10-аас доошгүй ус түгээх худагт ухаалаг систем суурилуулна.	Дэлгэрхаан сум 3, Батширээт 3, Баян-Адрага 1, Биндэр 2, Норовлин 3, Өмнөдэлгэр 2, Баян-Овоо 1 нийт 15 худаг ухаалаг системд холбогдоод байна.	80	100
<b>Зорилт 6.2.5. Сургуулийн барилга-өргөтгөл 6, дотуур байрны барилга 5, соёлын төвийн барилга 5, спорт заал, талбай 6, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 6, залуучуудын сургалт, хөгжлийн төв 2, ахмадын байр 1, иргэдэд үйлчлэх төв 10-ийг тус тус барьж байгуулна.</b>								

227	ЗДҮАХХАХТ 6.2.5.1 Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шинээр барьж, өргөтгөл хийж, их засвар хийнэ	-	тоогоор	Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсан.	төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдсэн байна.	Спорт заалны 2 барилга ашиглалтад орж 1 барилга 60%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 3-н иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын дундаж гүйцэтгэл 54%, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ахмадын сувиллын өргөтгөл байнгын ашиглалтад орсон. Бэрх тосгоны Олон улсын стандартын сургуулийн барилга 100%, 4-н сумын сургуулийн барилгын ажил гүйцэтгэл 71,5 %-ийн дундажтай үргэлжилж байна. Биндэр, Хэрлэн 4-р сургуулийн сургуулийн спорт заалны барилгын ажлын дундаж гүйцэтгэл 75% байна. 3-н цэцэрлэгийн барилга ашиглалтад орж 4-н цэцэрлэгийн барилга 30 хувийн дундаж гүйцэтгэлтэй байна. Хан Хэнтий чуулгын барилга 80%-ийн гүйцэтгэлтэй бол 5-н сумдын соёлын төвийн барилга 55,6 %-ийн гүйцэтгэлтэй байна. Шинээр хэрэгжиж байгаа 4-н эрүүл мэндийн төвийн дундаж хувь 32,5 бол шилжин хэрэгжиж байгаа эрүүл мэндийн төвийн барилга 86,6%-ийн гүйцэтгэлтэй байна.	100	100
<b>Зорилт 6.2.6. Сумын төвийн гэр хорооллын инженерийн, ариутгал татуургын шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламж, сум доторхи зам, төмөр бетон модон гүүрийг шинэчлэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ.</b>								
228	ЗДҮАХХАХТ 6.2.6.1. Сумын төвийн гэр хорооллын инженерийн болон ариутгах татуургын шугам сүлжээг байгуулна.	1500.0	тоогоор	7 сум ус хангамжийн системд холбогдсон.	Баянмөнх сумын гэр хорооллын шугам сүлжээний ажил дуусна. Сумдын гэр хорооллын шугам сүлжээний ТЭЗҮ боловсруулна.	Баянмөнх сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил бүрэн хэрэгжиж дууссан Мөн 9 Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч шалгарч тухай оны төлөвлөгөөт ажлыг хийж дуусгаад байна.	100	100
229	ЗДҮАХХАХТ 6.2.6.2 Шаардлагатай сумдын цэвэрлэх байгууламжийг засварлана.	200.0	Ажлын гүйцэтгэлээр	-	ТЭЗҮ боловсруулна.	Бор-Өндөр сум, Бэрх тосгоны ариутгах татуургын шугам сүлжээ цэвэрлэх байгууламжийг шинэчилж засварлах ажил хийгдсэн.	100	100
230	ЗДҮАХХАХТ 6.2.6.3 Сумын төвийн замыг сайжруулна.	0.0	ажлын гүйцэтгэлээр	Мөрөн, Өмнөдэлгэр сумын төвийн хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон.	Аялал жуулчлалын маршрутын дагуух сумын төвийн замыг сайжруулах ажил эхэлнэ.	Чингис хотын замын нөхөөс, явган хүний гэрлэн дохио, Баян-Адарга сумын төв, баруун даваа, шинэсийн авто замыг тэгшилж нягтруулах ажил бүрэн хэрэгжиж дууссан. 4-н зам-Хишигийн уулзвар-Хэрлэн зоогийн уулзвар хүртлэх замын шинчлэлтийн ажил үргэлжилж байна. Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн гаднах зам талбай, төв замаас орох хэсгийн замын зургийг дахин хийлгэж 2023 онд шийдвэрлэхээр болсон.	100	100

231	ЗДҮАХХАХТ 6.2.6.4. Аялал жуулчлалын маршрутын дагуух сумдыг хатуу хучилттай авто замаар холбоно.	300.0	Ажлын гүйцэтгэлээр	шинээр	ТЭЗҮ боловсруулна.	Чингис хот - Бэрх тосгон хүртэлх 70 км, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажил дуусаж ашиглалтад оруулсан. Бэрх-Норовлин чиглэлийн 130 км, Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн 52.5 км тус тус хатуу хучилттай авто замын ажлууд хийгдэж дунджаар 35%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Үүнээс гадна Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто замын энэ жилийн төлөвлөгөөт ажил хэрэгжээд байна.	100	100
<b>Зорилго 7.1. ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангах.</b>								
232	7.1.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнах	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Жил бүр хийгддэг.	Тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт үнэлгээ хийсэн. Мөн 16 сайдын гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> программд хугацаандаа баталгаажуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	100	100
233	7.1.2.Аймгийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг улирал тутам тайлагнах	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Жилд 1 удаа тайлагнадаг.	Тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явцын тайланг улирал бүр авч холбогдох газарт хугацаанд нь тайлагнасан.	100	100
234	7.1.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд ХШҮ хийн тайлагнах, нутгийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах	-	ХШҮ хийгдсэн эсэх	Жил бүр хийгддэг.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн ХШҮ-ний дүгнэлт гарсан байх	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 95.5 хувьтай үнэлж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> программд хугацаандаа баталгаажуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	100	100
235	7.1.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс аймагт хамаарах арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд ХШҮ хийж дүгнэлт гаргаж, дүнг удирдлагад танилцуулах	-	ХШҮ хийгдэж дүгнэлт гарсан эсэх	Жил бүр хийгддэг.	ЗГҮАХ-ийн арга хэмжээний - хэрэгжилтийн дүгнэлт гарсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2022 оны 11дүгээр сарын 25-нд 81.8 хувьтай үнэлэн удирдлагын зөвлөлд танилцуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	100	100



236	7.1.5.Аймгийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлд ХШҮ хийж дүгнэлт зөвлөмж гаргаж дүнг удирдлагад танилцуулан, тайланг аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГазар хүргүүлэх.	-	Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх	Жил бүр хийгддэг.	ХШҮ хийж, тайланг хугацаанд нь хүргүүлэх	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт, үнэлгээ хийж 91.6 хувьтай үнэлэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлүүлж, ЗГХЭГазарт хугацаанд нь хүргүүлсэн.	100	100
237	7.1.6.Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд ХШҮ хийж дүгнэлт гаргаж, ЗГХЭГ-т тайлагнах.	-	Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх	Жил бүр хийгддэг.	ХШҮ хийж, хугацаанд нь тайлагнах	Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2021 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 92,5 хувьтай үнэлж ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	100	100
328	7.1.7.Засаг даргын Тамгын газрын даргын батласан удирдамжийн дагуу агентлаг байгууллага, сумдад хяналт-шинжилгээ үнэлгээ хийх	-	ХШҮ хийсэн агентлаг байгууллага, сумдын тоо	Жил бүр хийгддэг.	Агентлаг, байгууллага болон сумдад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.	Сумдад хяналт-шинжилгээ үнэлгээ хийх график төлөвлөгөө гарган батлуулж эхний хагас жилд 7 суманд, сүүлийн хагас жилд 18 суманд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлсэн. Тус сумдын ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдэд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал сэдэвт сургалт хийсэн.	100	100
239	7.1.8.Сумдыг аймгийн ЗД-ын 2022 оны А/захирамжаар батлагдсан журмын дагуу үйл ажиллагааны үр дүнгээр байр эзлүүлэх.	-	Сумдын ерөнхий дүн гарсан эсэх	Жил бүр хийгддэг.	Сумдын үйл ажиллагааны ерөнхий дүн гарсан байна.	2022 оны ажлаараа Дадал сумын ЗДТГ 1-р байр, Бор-Өндөр сум 2-р байр,Өмнөдэлгэр сумын 3-р байранд шалгарсан.	100	100
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ</b>								
<b>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>Зорилт 2.1. Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэх баг байгуулж тус багаар дамжуулан холбох ажлыг зохион байгуулна.</b>								
240	2.1.1 Багийн гишүүдийн ажлын чиг үүргийг тодорхойлон төрийн 187 байгууллагад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Системд холбогдсон байгууллагын тоо	-	187-н төрийн байгууллагын 1129 албан хаагчид"erp.e-mongolia.mn" системд холбогдсон байна.	"erp.e-mongolia.mn" системийн хэрэглээнд ажлын хэсэг 1 удаа биечлэн 35 удаа цахимаар хяналт тавихад 1597 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа 100 хувь ашиглаж хэвшсэн байна.	100	100
<b>Зорилт 2.2. Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах хяналт тавих ажлыг зохион байгуулна.</b>								

241	2.2.1. "erp.e-mongolia.mn" системийг нэвтрүүлэх багийн гишүүдээр дамжуулан хуваарилагдсан байгууллагуудад сар, улирал тутам цахимаар болон биечлэн хяналт тавьж, хэрэглээг тогтмолжуулна.	-	Системийг хэрэглэж хэвшсэн албан хаагчдын тоо	60 хувь нь хэрэглэж хэвшсэн.	187 төрийн байгууллагын 1129 албан хаагчид 80 хувь нь хэрэглэж хэвшсэн байна.	www.erp.e-mongolia.mn системд төрийн 187 байгууллага тус бүрийн хүний нөөцийн системд нийт 4840 албан хаагчийн мэдээллийг оруулаад байна.	100	100
<b>Зорилт 2.3. "E-MONGOLIA" системийн ач холбогдлыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлан таниулна</b>								
242	2.3.1. Иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын албан хаагчдад тулгуурлан сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.	-	Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоо	2021 онд нийт биечлэн үйлчилгээ авсан иргэдийн тоо 253.831	Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 5 хувиар бууруулна.	Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 15 хувиар бууруулж 21 аймгаас E-mongolia хэргэлсэн иргэдийн тоогоор 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 5 дугаарт эрэмбэлэгдсэн.	100	100
<b>Зорилт 2.4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагын 4500 төрийн албан хаагчид болон 120 чиглүүлэгч 791 аравт, хэсгийн ахлагч нарт E-MONGOLIA системийг танилцуулах сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.</b>								
243	2.4.1 Жилд 2 удаа сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.	ОНТ	Сургалт зохион байгуулсан тоо	8 удаа сургалт зохион байгуулж 3800 төрийн албан хаагчдыг хамруулсан.	2 удаа сургалт зохион байгуулсан байна.	2022 онд E-mongolia системийн ашиглалтын талаарх танилцуулга сургалтыг 18 сумын 88 багт аймгийн удирдлагууд ажиллахад болон сумын е хөтөч хариуцсан албан хаагчид багийн иргэдийн нийтийн хурал дээр тус тус аймгийн хэмжээнд баг бүрт 2 удаагийн сургалт зохион байгуулж 14000 гаруй иргэнийг хамруулсан.	100	100
<b>Зорилт 2.5 Төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтийг хангуулах</b>								
244	2.5.1 Төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан зорилтыг хэрэгжүүлэнэ	ОНТ	Тоо	АТТ-д заасан зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан.	АТТ-д заасан зорилтуудыг хэрэгжүүлсэн байна.	АТТ-д заасан зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан.	100	100
<b>Нийт үнэлгээний дундаж</b>							<b>98.9</b>	<b>94.8</b>